



Эдийн Засгийн Хөгжлийн яам

## Эцсийн тайлан

**“Үнийг нь зохицуулах шаардлагатай гол нэрийн бараа, бүтээгдэхүүний зах зээл, хэрэглээний төлөв байдал, чиг хандлага, хангамж нийлүүлэлт, үнэ бүрдэлт” сэдэвт бодлогын судалгаа**

Макро Эдийн Засаг ба Эрүүл Мэнд ТББ

2014.04.25.

**Судалгааны баг**

**Д.Чимэддагва-Эдийн засгийн ухааны магистр**

**Б.Батмөнх-Эдийн засгийн ухааны доктор**

**Я.Балгансүрэн-Физик, математикийн ухааны дэд доктор**

**А.Сайнзаяа- МУИС-н Бизнесийн сургуулийн оюутан**

## Агуулга

Удиртгал.....	5
Оршил .....	5
Судалгааны зорилго .....	6
Судалгааны ажлын хамрах хүрээ.....	6
Судалгааг хийх аргачлал, арга зүй, төлөвлөгөө.....	7
<i>БҮЛЭГ-1 Үнэ тогтворжуулалтын онолын үндэслэл, олон улсын туршлага, цаашдын хандлага.....</i>	<i>9</i>
1.1. Үнэ тогтворжуулалтын онолын үзэл баримтлал:.....	9
1.2. Үнийн тогтворгүй байдлын төрлүүд:.....	11
1.3. Үнийн тогтворгүй байдлын үр дагавар:.....	13
1.4. Үнэ тогтворжуулах бодлогын зорилго, үр нөлөө: .....	14
1.5. Үнэ тогтворжуулалтын аргууд:.....	15
1.6. Үнэ тогтворжуулалтын олон улсын зарим туршлага .....	17
<i>БҮЛЭГ-2 Монгол Улсад үнийг нь зохицуулах шаардлагатай гол нэрийн бараа, бүтээгдэхүүний зах зээл, хэрэглээний төлөв байдал .....</i>	<i>29</i>
2.1 Монгол Улсад үнийг зохицуулах шаардлагатай бараа, бүтээгдэхүүний нэр төрөл..	29
2.2 Үнийг нь зохицуулах шаардлагатай гол нэрийн бараа, бүтээгдэхүүний зах зээл, эрэлт нийлүүлэлтийн төлөв байдал .....	34
2.3 Монгол Улсын гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн улирлын хэлбэлзэлд хийсэн шинжилгээ, нийлүүлэлтийн саад тотгорууд .....	38
<i>БҮЛЭГ 3. Үнийг нь зохицуулах шаардлагатай гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ бүрдэлтийн байдал, нийлүүлэлтийн саад хязгаарууд .....</i>	<i>52</i>
3.1 Монгол Улсын өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ бүрдэлтийн байдал...	52
3.2. Улаанбаатар хотын хэрэглэгчдийн махны хангамжийн замын зураглал .....	52
3.3.Улаанбаатар хотын гэр хорооллын хэрэглэгчдийн түлээ, нүүрсний хангамжийн замын зураглал ба үнэ бүрдэлтийн байдал.....	58
3.4. Импортын цагаан будааны замын зураглал.....	62
3.5. Төмс, хүнсний ногооны нийлүүлэлтийн замын зураглал.....	64
3.6 Шатахууны үнэ бүрдэлт .....	65
Дүгнэлт .....	66
Санал, зөвлөмж .....	68
Ном зүй .....	70

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.1 Энэтхэгийн үнэ тогтворжуулах сангийн онцлог .....	17
Хүснэгт 1.2 Тайваны ХАА-н бодлогын ерөнхий бүтэц .....	22
Хүснэгт 1.3 Үнэ тогтворжуулалтын стратегийн ABCD матриц .....	25
Хүснэгт 2.1 Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд хамгийн өндөр хувийн жин эзэлдэг нэр төрлүүд .....	29
Хүснэгт 2.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд үнэ нь хамгийн их хэлбэлзэлтэй нэр төрлүүд .....	31
Хүснэгт 2.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний дотроос үнэ нь хамгийн өссөн нэр төрлүүд, өсөлт дахинаар .....	32
Хүснэгт 2.4 Шинээр үнийг нь төрөөс хянаж, зохицуулах шаардлагатай нэр төрөл ....	33
Хүснэгт 2.5 Гол нэрийн зарим бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт.....	35
Хүснэгт 2.6 Гол нэрийн зарим бараа, бүтээгдэхүүний нийт эрэлт.....	36
Хүснэгт 2.7 Гол нэрийн зарим бараа, бүтээгдэхүүний нийт эрэлтийн бүтэц, хувиар .....	37
Хүснэгт 2.8 Хэрэглээнд зарцуулсан малын тоо, малын төрлөөр, мянга .....	37
Хүснэгт 3.1 Цагаан будаа импортолж, борлуулах замын зураглал .....	63
Хүснэгт 3.2 Гаалиас эцсийн хэрэглэгч хүртэлх цагаан будааны үнэ, төгрөгөөр .....	63
Хүснэгт 3.3 Төмсний үйлдвэрлэл, импорт, тонн .....	64
Хүснэгт 3.4 Шатахууны үнэ 2014 оны 4 дүгээг сарын 20 –ны байдлаар .....	65

## Зургийн жагсаалт

Зураг 1.1 Импортлогдсон тогтворгүй байдал.....	12
Зураг 1.2 Эндоген тогтворгүй байдал (“аалзны тор”-ын тохиолдолд).....	13
Зураг 1.3 Канадын орлого тогтворжуулах хөтөлбөрт Засгийн газрын оролцоо.....	21
Зураг 1.4 Үнэ тогтворжуулах хэрэгслүүдийн үр нөлөө .....	27
Зураг 2.1 Хэрэглээний нийт бараа, үйлчилгээний болон хүнсний бүтээгдэхүүний үнийн сүүлийн 2 жилийн сар бүрийн өөрчлөлт, хувиар .....	38
Зураг 2.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний болон хүнсний бүтээгдэхүүний үнийн суурь үетэй харьцуулсан өсөлт, 2005 оны 12 сар=100, хувиар .....	39
Зураг 2.3 Дэлхийн болон Монголын зах зээл дэх хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн хувь, 2005=100.....	40
Зураг 2.4 Хэрэглээний бараа,үйлчилгээний болон хүнсний бүтээгдэхүүний үнийн улирлын индекс, 2006-2013 он .....	41
Зураг 2.5 Хэрэглээний бараа,үйлчилгээний болон хонь, үхрийн махны сүүлийн 8 жилийн сар бүрийн үнийн өөрчлөлт, хувиар.....	43
Зураг 2.6 Дэлхийн болон Монголын зах зээл дэх үхрийн махны үнийн өсөлтийн хувь, 2005=100.....	44

Зураг 2.7 Хэрэглээний бараа,үйлчилгааний болон хүнсний ногооны сүүлийн 8 жилийн сар бүрийн үнийн өөрчлөлт, хувиар.....	45
Зураг 2.8 Хэрэглээний бараа,үйлчилгааний болон гурил, цагаан будааны сүүлийн 8 жилийн сар бүрийн үнийн өөрчлөлт, хувиар.....	46
Зураг 2.9 Дэлхийн болон Монголын зах зээл дэх гурилын үнийн өсөлтийн хувь, 2005=100.....	47
Зураг 2.10 Дэлхийн болон Монголын зах зээл дэх цагаан будааны үнийн өсөлтийн хувь, 2005=100 .....	48
Зураг 2.11 Хэрэглээний бараа,үйлчилгааний болон түлшний мод, нүүрсний сүүлийн 8 жилийн сар бүрийн үнийн өөрчлөлт, хувиар.....	49
Зураг 2.12 Хэрэглээний бараа,үйлчилгааний болон шатахууны сүүлийн 8 жилийн сар бүрийн үнийн өөрчлөлт, хувиар.....	50
Зураг 2.13 Дэлхийн зах зээл дээрх шатахууны үнийн хэлбэлзэл .....	51
Зураг 3.1 Улаанбаатар хотын хэрэглэгчдийн махны хангамжийн замын зураглал ....	56
Зураг 3.2 Улаанбаатарт нийлүүлэгдэж буй махны хэмжээ аймаг тус бүрээр.....	57
Зураг 3.3 Нүүрс нийлүүлэлтийн замын зураглал.....	58
Зураг 3.4 Налайхын нүүрсний үнэ бүрдэлтийн байдал .....	59
Зураг 3.5 Орон нутаг дахь нүүрсний нийлүүлэлтийн замын зураглал.....	60
Зураг 3.6 Цагаан будааны замын зураглал.....	64

### **Хавсралт хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Улаанбаатар хотын гол нэрийн бараа үйлчилгээний жилийн дундаж үнэ	
Хүснэгт 2. Гол нэрийн бүтээгдэхүүний үнэ, нийлүүлэлт, аймгаар	
Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ, аймгаар (2011-2013)	
Хүснэгт 3.1. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний улирлын үнэ, аймгаар (2011-2013)	
Хүснэгт 4. Улаанбаатар хотын махны үнэ, улирал, захуудаар	
Хүснэгт 5. Импортын хүнсний ногоо, булцуут ба үндэс үрт хүнсний ургамал	
Хүснэгт 5.1. Импортын жимс, жимсгэний ургамал, самар, жүржийн буюу гуаны төрлийн жимсний хальс	
Хүснэгт 5.2. Импортын, үр тариа	
Хүснэгт 5.3. Экспорт, импортын мах	
Хүснэгт 5.4. Эрдэс түлшний экспорт, импорт	
Хүснэгт 5.5. Хүнсний ногоо, булцуут ба үндэс үрт хүнсний ургамалын импорт	
Хүснэгт 5.6. Жимс жимсгэний ургамал, самар жүржийн буюу гуаны төрлийн жимсний хальсний импорт	
Хүснэгт 5.7. Үр тарианы импорт	
Хүснэгт 5.8. Махны экспорт, импорт	
Хүснэгт 5.9. Эрдэс түлшний экспорт, импорт хувиар	
Хүснэгт 6. Хураасан төмс, хүнсний ногоо,үр тариа, тэжээлийн ургамал, бүс, аймаг, нийслэлээр, жилээр	

## Удиртгал

### Оршил

Зах зээлийн эдийн засгийн нөхцөл дэх төрийн нэг чухал үүрэг бол макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах явдал байдаг. Инфляци нь шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьд макро эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлдөг гол хүчин зүйлийн нэг бөгөөд улсын төсөв, валютын ханш, зээлийн хүү, цалин, ядуурлын түвшин гэх мэт эдийн засаг, нийгмийн хөгжлийн олон үзүүлэлтүүдэд хүчтэй, шууд нөлөөг үзүүлдэг.

Манай орны инфляцийг судалсан гадаадын болон дотоодын судлаачдын судалгаанаас харахад хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт харьцангуй өндөр өсч ирсэний дотор улирлын ихээхэн хэлбэлзэлтэй байна. Энд хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэмжээ улирлын шинжтэй байгаа нь ихээхэн нөлөөтэй байгаа ажээ. Зарим бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт инфляцийн ерөнхий түвшинд ихээхэн нөлөөлж иржээ. Суурь бүтээгдэхүүн болох шатахууны үнийн өсөлт нь нийт хэрэглээний үнийн сагсны бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөх гол нөхцөл болсоор ирсэн байдаг. Ялангуяа хүнсний бүтээгдэхүүний үнийг томоохон баяр, наадмын өмнө дураар нэмэгдүүлэх, зохиомол хомсдол үүсгэж үнэ өсгөх үзэгдэл гарч, олон шат дамжлагаар дамжиж хэрэглэгчдэд хүргэж байгаа нь үнэ өсөх бас нэг шалтгаан болсоор иржээ.

Монгол улсад гол нэрийн зарим бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл, үнэд төрөөс зохицуулах зохицуулалтын хэлбэр, оролцоо ямар байх талаар нарийн тодорхой бодлого байхгүйн улмаас хэрэглэгчдийн эрх ашиг хөндөгдөх, шударга бусаар өрсөлдөх үзэгдэл гарсаар байна. Мөн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт, хангамжийн тогтвортой байдал болон баталгаат байдал алдагдах, хомсдох, хэт өндөр үнэ тогтоох зэрэг үзэгдэл гарч байна. Эдгээр байдал нь хүн амын амьжиргаанд сөргөөр нөлөөлөх, эдийн засгийн тогтворгүй байдал үүсгэх, улмаар үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөлж болзошгүй байдал бий болж байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийн түвшин 10 хувиар байнга давж гарч, Монгол банкны мөнгөний бодлогод дэвшүүлсэн зорилтот түвшингээс тухай бүр нь хэтрээд байгаа билээ. Үүнд ерөнхий судалгаа хийж үзэхэд бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хомсдлоос үүдэлтэй үнийн өсөлт давамгайлсан байна.

Хэдийгээр зарим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг төрөөс зохицуулалт хийдэг боловч энэ нь инфляцийн түвшин нам байхад төдийлөн сайн нөлөөлж чадахгүй байна. Иймд Монгол Улстай ижил, төстэй улс орнуудын хувьд энэ чиглэлээр судалгаа хийж, хэрэглээний гол нэрийн барааны үнэ бүрдэлтийн замын зургийг нийлүүлэлтийн гинжин хэлхээний үе шат бүрт гаргаж, Монгол Улсын хувьд ямар, ямар бараа, бүтээгдэхүүний үнийг төрөөс зохицуулах шаардлагатай байгааг тодорхойлох нь нэн тулгамдсан асуудал болоод байна. Үүний зэрэгцээ эдгээр бараа, бүтээгдэхүүний үнэ бүрдэлтийн шат дамжлагад судалгаа хийж, үйлдвэрлэгч, импортлогчоос хэрэглэгчид хүрэх шат, дамжлагийг цөөрүүлэх, үнийн зохиомол өсөлтөд хяналт тавих, төрөөс оролцож зохицуулах арга замын талаар бусад орнуудын туршлагыг харгалзан санал, дүгнэлт гарагах шаардлагатай байгаа болно.

### **Судалгааны зорилго**

Энэхүү бодлогын судалгааны зорилго нь хэрэглэгчдэд хүрч буй хэрэглээний гол нэр төрлийн бүтээгдэхүүний бодит үнэ бүрдлийг гаргаж, үнийг нь зохицуулах шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тодорхойлж, хууль эрх зүйн орчныг бий болгох зөвлөмж боловсруулахад оршино.

### **Судалгааны ажлын хамрах хүрээ**

- Монгол Улстай ижил төстэй эдийн засагтай 4-5 улсын бодлогын харьцуулсан судалгаа, инфляцийн түвшинг эдийн засгийн өсөлттэй хэрхэн уялдуулан бууруулсан арга зам, хууль, эрх зүйн зохицуулалтын бодит жишээ, загварыг судалж тусгана.
- Хэрэглээний гол нэрийн барааны үнэ бүрдэлтийн замын зургийг нийлүүлэлтийн гинжин хэлхээний үе шат бүрт нарийвчлан гаргаж, нийлүүлэлтийн саад хязгаарлалтуудыг илрүүлсэн байна.
- Судалгааны хүрээнд илрүүлсэн саад, хязгаарлалтуудыг арилгах, тогтвортой байдлыг хангах замаар үнийг тогтворжуулах иж бүрэн арга хэмжээний талаар бодлогын санал, зөвлөмж бэлтгэсэн байна.
- Энэхүү судалгааны үндсэн дээр үнийг нь зохицуулах шаардлагатай бараа, бүтээгдэхүүний үнийг зохицуулах талаар хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох үүднээс хуульд оруулах заалтуудыг томъёолж, санал дэвшүүлэх.
- Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ ашигласан загварыг дэлгэрэнгүй танилцуулж, цаашид уг загварыг үргэлжлүүлэн ашиглахад зориулж, холбогдох мэргэжилтэнгүүдэд сургалт зохион байгуулсан байна.

- Монгол Улстай ижил төстэй эдийн засагтай улс орнуудын үнэд төрөөс хяналт тавьдаг арга замыг судална.
- Монгол Улсын гол нэрийн бараа, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн механизм, улирлын хэлбэлзэл, үнэ бүрдэлтэнд шинжилгээ хийнэ.

### **Судалгааг хийх аргачлал, арга зүй, төлөвлөгөө**

“Үнийг нь зохицуулах шаардлагатай гол нэрийн бараа, бүтээгдэхүүний зах зээл, хэрэглээний төлөв байдал, чиг хандлага, хангамж нийлүүлэлт, үнэ бүрдэлт” сэдэвт бодлогын судалгааг хийхдээ дараах арга зүйг ашиглав.

1.Эхний ээлжинд баримтын судалгааны аргыг ашиглан зах зээл хөгжсөн болон манай оронтой хөгжлийн түвшин ойролцоо орнуудад төрөөс үнийн зохицуулалт хийдэг хууль эрх зүйн орчин болон зохицуулалтын арга хэлбэрийн талаар материал хайж, судлана.

2. Статистикийн аргуудыг ашиглан үнийг нь зохицуулах шаардлагатай гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нэр төрлийг тогтооно. Ингэхдээ дараах шалгуур үзүүлэлт аргачлалыг ашиглана.Эхний ээлжинд хэрэглээний үнийн өсөлт буюу инфляцид ихээхэн нөлөөтэй байдаг хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд өндөр хувийн жин эзэлдэг бараа, бүтээгдэхүүнийг харгалзан үзэв. Дараагийн шатанд статистикийн аргууд ашиглав. Бидний хувьд инфляцийг тооцдог хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд орсон нэр төрлийн дотор үнэ нь хамгийн тогтворгүй хэлбэлзэж байдаг нэр төрлийг тогтоох зорилт тавьсан.

Аливаа тоон олонлогын их, бага утгуудын хоорондох хэлбэлзлийг статистикт дисперс, түүнээс язгуур гаргах замаар тооцдог квадрат дундаж хэлбэлзэл (англиар Standard Deviation) , вариацийн коэффициент ( The coefficient of variation) гэдэг үзүүлэлтээр хэмждэг. Хэлбэлзлийн эцсийн үнэлгээг вариацийн коэффициентыг үндэслэн хийдэг бөгөөд уг коэффициент 30 хувиас өндөр гарсан тохиолдолд хэлбэлзэл маш ихтэй гэж үздэг. Хэрэв энэ коэффициент 15-30 хооронд байвал дунд зэргийн хэлбэлзэлтэй гэж үздэг. Үнэ нь хамгийн тогтворгүй хэлбэлзэж байдаг нэр төрлийг тогтоохын тулд хэлбэлзлийн статистик үзүүлэлтүүдийг сагны бүх 287 нэр төрлөөр<sup>1</sup> 2010 оны 1 дүгээр сараас 2013 оны 12 дугаар сарыг дуустал хугацааны үнийн өөрчлөлтийг үндэслэн тооцов.

---

<sup>1</sup> ҮСХ нь 2005-2011 оны хооронд 287 нэр төрлийг хэрэглээний барааа, үйлчилгээний сагсанд оруулдаг байснаа 2012 оноос сагсныхаа нэр төрлийг 329 болгож өргөжүүлсэн. Бид 2012 болон 2013 оны нэр төрлүүдийг өмнөх онуудтай зэрэгцэхүйц байхаар хуучин сагсаны нэр төрөлд шилжүүлэн тооцов.



3. Статистикийн түүвэрлэлтэд гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг борлуулдаг томоохон зах, худалдааны цэгүүдийг сонгов.

4. Тандалтын судалгаагаар эхний ээлжинд тухайн бүтээгдэхүүнийг УБ-т хүн амд голлон зардаг зах, борлуулалтын цэгээ тогтоож, бүтээгдэхүүнээсээ хамаараад 3 -аас доошгүй зах сонгосон. Сонгосон захаасаа худалдагч нараас тухайн бүтээгдэхүүн ямар эх үүсвэрээс хаа хаанаас голчлон нийлүүлэгдэж байгааг нийт нийлүүлэлтэнд эзлэх ойролцоо хувийг асууж тогтоов.

Дараагийн ээлжинд голлон нийлүүлэгчдээс ( ихэвчлэн ченжүүдээс) нийлүүлэлтийн шат дамжлага бүр анхан шатнаасаа зах хүртэлх ямар ямар замыг туулж ирснийг асуулга авсан өдрийн үнийн хамт асууж тандав.

5. Нийслэл болон орон нутагт үндсэн судалгааг явуулав. Энэхүү судалгаа нь экспертизийн судалгааны аргаар хийгдсэн. Энд сонгосон нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтэд оролцдог компани, байгууллага, ченжүүдээс судалгааг авсан.

### ***БҮЛЭГ-1 Үнэ тогтворжуулалтын онолын үндэслэл, олон улсын туршлага, цаашдын хандлага***

#### ***1.1. Үнэ тогтворжуулалтын онолын үзэл баримтлал:***

Зах зээлийн үнэ бүрдэлт нь зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийн үндсэн дээр бүрдэж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааг эрхлэгчдэд мэдээлэл болж ирээдүйн шийдвэрээ гаргахад нь тусалж байдаг. Эдийн засгийн сонгодог онолчдын үзлээр зах зээлийн “үл үзэгдэгч гар” нь зах зээлийг илүү оновчтой зөв байдлаар зохицуулж байдаг тул төрийн зохицуулалт хийх нь энэхүү механизмын үйл ажиллагааг алдагдуулж, бүх оролцогчдод богино хугацаанд биш гэхэд урт хугацаанд сөргөөр нөлөөлдөг гэж үздэг. Хэдийгээр энэхүү үзэл баримтлал ихэнх тохиолдолд үнэн байх ч боловсрол, эрүүл мэнд, ялангуяа хөдөө аж ахуйн хүнсний бүтээгдэхүүний хувьд тэр бүр үйлчилж чаддаггүй. Учир нь үнээр баримжаалан өөрчлөгдөх эдийн засгийн оролцогчдын тариалах бүтээгдэхүүний сонголт, тариалах талбайн хуваарилалт зэрэг нь үйлдвэрлэгчдэд богино хугацаанд ашиг олохуйцаар өөрчлөгдөж болох ч үнийн мэдрэмж муутай хүнсний бүтээгдэхүүний эрэлт нь хүн амын өсөн нэмэгдэж буй тоо, хэрэгцээнээс хамаарч буурах боломжгүй юм. Ийм нөхцөлд хэрэв хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийг зах зээлийн зөнгөөр нь тавьж, байнгын хэлбэлзэлд хэвээр байлгавал тухайн улс орны ард иргэдийн хүнсний аюулгүй байдал, цаашлаад макро, микро эдийн засгийн байдлууд дунд урт хугацаанд тогтворгүй байдалд шилжинэ. Түүнчлэн, үнийн дохиоллыг баримжаалагчид богино хугацааны ашгийг хамгийн их хүргэх зорилгодоо дулдуйдан хөдөө аж ахуйн салбарт оруулах хөрөнгө оруулалтыг хийхгүй, өөр бусад ашигтай хүнсний бус бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах эрсдэлтэй юм. Энэ бүгдээс үүдээд ихэнх улс орнууд түүхийнхээ явцад хөдөө аж ахуйн хүнсний бүтээгдэхүүн, эсвэл тухайн улсын гол нэрийн бүтээгдэхүүнийхээ үнийг тогтворжуулах зорилгоор төрөөс тодорхой хэмжээгээр зохицуулалт хийсээр иржээ.

Үнэ тогтворжуулалт нь үнийн тогтворгүй байдлыг бууруулах, түүнээс үүдэн гарах үр нөлөөг багасгах үндсэн зорилгуудтай байдаг. Гэхдээ аль зорилгыг голлон тавьснаас хамаарч ямар хэрэгсэл, арга механизмуудыг ашиглахыг шийдвэрлэдэг.

Үнийн тогтворгүй байдлыг төрөөс зохицуулах арга хэрэгслүүдийг дэлхийн II дайны дараагаас хэрэглэж эхэлсэн. Нэрт эдийн засагч Кейнс тэргүүлсэн эдийн засагчид олон улсын үнийг тогтворжуулахад шаардлагатай хэрэгслүүдийг санал болгож байсан ба энэ нь сахар (1954), кофе (1962),

какао (1972) болон байгалийн каучук (1980) зэргийн үнийг тогтворжуулах зорилготой “Олон улсын барааны хэлцлүүд”-д биелэлээ олсон. Уг үзэл баримтлал нь 1976 онд НҮБ-ийн Худалдаа, Хөгжлийн хуралдаанаар санал болгосон “Бараа таваарын нэгдсэн хөтөлбөр”-т хамгийн их нөлөө үзүүлсэн бөгөөд энэхүү хөтөлбөр нь гол нэр төрлийн 10 барааны үнийг тогтворжуулах замаар “олон улсын эдийн засгийн шинэ дэг журам”-ыг тогтоох зорилготой байсан.

Гэвч 1980-аад онд эрдэмтэн судлаач нар (Newbery & Stiglitz, 1981) үнэ тогтворжуулалт нь эерэг үр нөлөөтэй эсэх талаар шүүмжлэлтэй хандах болж, улмаар улс төрчид ч үнэ тогтворжуулах механизмуудаас аажмаар татгалзсан (Gilbert, 1996). Эдгээр шүүмжлэлийн гол агуулга нь хөдөө аж ахуйн үнийг тогтворжуулах оролдлого нь хоёр үндсэн шалтгаанаар сайн зүйл биш юм. Нэгд, энэ нь үнийг зах зээлийн гол дохиолол болоход нь саад хийдэг. Ингэснээр үйлдвэрлэгч, худалдаачид нь эрэлт нийлүүлэлтээр зах зээлийн үнийг тогтоож, үйл ажиллагаагаа удирдахад бэрхшээлтэй болно. Хоёрт, үнийн хөдөлгөөнийг үйлдвэрлэлийн өөрчлөлтөөс салгаснаар хөдөө аж ахуй эрхлэгчид нь үнэ болон ургац хураалтын хэмжээний урвуу хамаарлаас үүдэн бий болдог “төрөлхийн даатгал”-ын ач тусыг хүртэх боломжгүй болдог.

Эдгээрээс сэргийлэх сайн арга зам бол үнийг шууд өөрчлөлгүйгээр, харин эрсдлийг даатгах зах зээлийн хэрэгслүүдийг (фьючерс, опцион г.м) эмзэг бүлгийн өрх гэрүүдэд нийгмийн халамж үзүүлэх механизмуудтай хамтад нь хэрэглэх явдал гэж үзэх болсон. Гэвч эрсдлийг даатгах зах зээлийн хэрэгслүүдийг хэрэглэх оролдлого нь хөгжиж буй байтугай өндөр хөгжилтэй оронд ч гэсэн төдийлөн үр дүнгээ өгч чадаагүй (CRMG, 2008). Иймд судлаачид зах зээлийг шинэчлэх арга механизмыг ашиглах нь зүйтэй гэж үзэх болсон (Byerlee, T.S.Jayne, & R.Myers, 2005). Энэ дагуу зарим улс орнуудад үр тарианы зах зээлийг шинэчлэх өөрчлөлтүүдийг 2000-д онд хэрэгжүүлж эхэлсэн. Хэдий тийм ч 2008 оны олон улсын зах зээлийн хямрал нь чөлөөт худалдаа, эрсдлийн удирдлагын арга хэрэгслүүдийн сул талыг харуулсан. Иймд хүнсний бүтээгдэхүүний дэлхийн хямралыг даван туулахтай холбогдуулан Олон Улсын Хүнсний Бодлого Судалгааны Институт, Дэлхийн Банк зэрэг байгууллагуудаас санал болгосон үр тарианы олон улсын зах зээлийн үнийг тогтворжуулах бодлогууд нь үнийг тогтворжуулахад төрийн зохих хэмжээний оролцоо зайлшгүй хэрэгтэй болохыг дахин сануулсан байна (von Braun & Torero, 2008; Von Braun & Torero, 2009a, 2009b).

### **1.2. Үнийн тогтворгүй байдлын төрлүүд:**

Үнийн тогтворгүй байдлыг үүссэн шалтгаанаас нь хамааруулан “төрөлхийн”, “импортлогдсон”, эндоген гэсэн 3 төрөлд ангилж болно (Galtier, 2013).

**“Төрөлхийн” тогтворгүй байдал** гэж нэрлэсэн нь үүнийг бий болгодог 2 үндсэн байгалийн шалтгаантай холбоотой. Үр тарианы хураалт нь *улирлын чанартай* байдаг тул ургац хураалтын дараа тоо хэмжээний их байдлаас хамаарч үнэ нь буурсанаа, нөөц барагдаад ирэх үед үр тарианы үнэ оргил цэгтээ хүрдэг. Энэхүү үнийн өсөлт нь дараагийн ургац хураалт хүртэл үргэлжилж, аажмаар хураалт болоход эргээд буурдаг улирлын шинжтэй юм. Байгаль болон цаг уурын гамшигаас хамаарч жил бүрийн *ургацын хэмжээ* нь харилцан адилгүй байдаг. Энэхүү хэмжээний ялгаатай байдал нь цаг уурын таагүй явдлууд болох үер, ган зэрэг нь хэр давтамжтай болдог, үр тарианы тариалалт нь эдгээр байгалийн аюулд хэр мэдрэмжтэй байдаг (ган, зуднаас хамгаалсан арга хэмжээ, услалтын сайн систем зэргийн ачаар энэхүү мэдрэмжтэй байдлыг тодорхой хэмжээгээр бууруулах боломжтой) зэргээс ихээхэн хамаардаг. Улирлын болон хураалтын хэмжээний ялгаатай байдлууд нь хоорондоо харилцан уялдаатай байж болох ба хураалтын хэмжээний хэлбэлзэл нь үнийг урьдчилан таамаглахад илүү хэцүү байдлаар өөрчилж болдог үзэгдэл юм.


**“Импортлогдсон” тогтворгүй байдал:** Дотоодын үнэ нь гадаад зах зээлийн үнээс тодорхой хэмжээгээр хамааралтай байдаг учир аливаа улс оронд гадаад худалдааны үр нөлөөгөөр үнийн тогтворгүй байдал бий болж болдог. Үр тарианы импортын тэнцвэрт үнэ ( $P_M$ ) нь дотоодын үнийг тодорхойлох ба энэ нь олон улсын CIF (өртөг-даатгал-тээвэрлэлт) үнийг үндэсний валютад хөрвүүлсэн дүн дээр импортын татвар, хилээс дотоодын зах зээл хүртэлх тээвэрлэлтийн зардал зэргийг нэмсэн дүн байна. Иймд дотоодын үнэ нь ( $P_M$ )-ээс өндөр байх боломжгүй бөгөөд хэрэв тийм байдал үүсвэл тухайн улсын зах зээл импортоор дүүрэх болно. Экспортын тэнцвэрт үнэ ( $P_X$ ) нь ч гэсэн дотоодын үнэд ижил нөлөө үзүүлдэг. Дотоодын зах зээлийн үнэ нь экспортын үнээс доош орж болохгүй бөгөөд ингэсэн тохиолдолд бүх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гадагш экспортлогдоход хүрнэ. Иймд дотоодын үнэ нь ( $P_M$ ) болон ( $P_X$ ) тэнцвэрт үнүүдийн хооронд оршиж байдаг. Олон улсын зах зээлийн үнийн өөрчлөлт, валютын ханшны өөрчлөлт, гадаад тээвэрлэлт болон далайн тээврийн өртөг өөрчлөгдөх зэргээс шалтгаалж ( $P_M$ ) болон ( $P_X$ ) тэнцвэрт үнүүдийн аль нэгэнд гарсан өөрчлөлт нь дотоодын зах зээлийн үнийг тогтворгүй байдалд оруулах юм.

Импортлогдсон тогтворгүй байдал нь тэнцвэрт үнүүдээс хамааран дээшлэх, доошлох хөдөлгөөн хийж буй үнийн хэлбэлзлээр илэрхийлэгдэнэ (Зураг 1-


ийг үзнэ үү). Энэхүү жишээн дээрээс харахад олон улсын үнэ өндөр тохиолдолд тухайн улс нь олон улсын зах зээл дээр тоглолт хийх шаардлагагүй болдог (а тохиолдолд). Учир нь олон улсын зах зээл дээр тогтсон импортын үнэ нь өндөр, экспортын үнэ нь доогуур тул гадаад худалдаа хийх нь ашиггүй. Харин олон улсын үнэ бага үед (б тохиолдолд) тухайн улс нь импортлогч улс болно.

### Зураг 1.1 Импортлогдсон тогтворгүй байдал

а. Олон улсын зах зээлийн өндөр үнийн үед



б. Олон улсын зах зээлийн бага үнийн үед




Эх сурвалж: F. Galtier (2013) “Managing food price instability in developing countries: A critical analysis of strategies and instruments”, (46-р тал)


**Эндоген тогтворгүй байдал нь** зах зээлийн дотоод үйл ажиллагаанаас, ялангуяа оролцогчдын хүлээлт, зан төлөвөөс үүдэн үнийн тогтворгүй байдал бий болсон үед үүсдэг (Boussard, F.Gerard, M.G.Piketty, M.Ayouz, & T.Voituriez, 2006). Ихэнх шийдвэр нь оролцогчдын таамаглаж буй ирдээдүйн үнийн хүлээлт дээр үндэслэн гардаг. Үүний гол жишээ нь Ezekiel (1938)-ийн *cobweb* буюу “аалзны тор”-ны хувилбарт тодорхой харагддаг. Энгийн нөхцөлд “аалзны тор” нь өнөөгийн үнэ нь хүлээгдэж буй үнэтэй тэнцүү гэж үздэг. Хэрэв  $P_t$  буюу өнөөгийн үнэ өндөр байвал тариаланчид илүү их талбайд үр тарих, ургацаа нэмэгдүүлэх арга хэмжээ авсанаар  $P_{t+1}$  хугацаанд үнэ буурна. Эсрэгээр хэрэв  $P_t$  бага бол тариалалт буурч  $P_{t+2}$  хугацаанд үнэ өсөхөд хүрнэ. Хэдийгээр Ezekiel-ийн жишээ нь хэт энгийн боловч илүү бодит байдал болон оролцогчид нь өнгөрсөн хугацааны үнэд үндэслэн шийдвэр гаргаж байгаа үед ч энэхүү механизм үйлчилдэг гэж үздэг (Nerlove, 1958).

**Зураг 1.2 Эндоген тогтворгүй байдал (“аалзны тор”-ын тохиолдолд)**

а. 1 болон 2-р үеүүдэд



б. Дараачийн үеүүдэд



Эх сурвалж: F. Galtier (2013) “Managing food price instability in developing countries: A critical analysis of strategies and instruments”, (49-р тал)

Эндоген тогтворгүй байдал нь зах зээлийн гадаад бус дотоод хүчин зүйлс болох хүлээлт, тоглогчдын зан төлөвөөс хамаарч үүсдэг тул эрэлт, нийлүүлэлтийн шулууны дагуух хөдөлгөөнөөр илэрхийлэгдэнэ (Зураг 2-ыг харна уу). Иймд ашиг хонжоо хайсан үнийн хөөсрөлт, бууралт зэрэг нь хувирамтгай байдалд хүргэж, аалзны тор хэлбэрийн динамиктай үнийн хэлбэлзлийг үүсгэдэг.

Эдгээр 3 төрлийн үнийн тогтворгүй байдлын бодит жишээ олон бий. Тухайлбал, 1970-д онд гангаас үүдсэн бага ургац хураалтаас хамаарч бий болсон Сахелийн хямрал нь “төрөлхийн” тогтворгүй байдлын жишээ юм. Харин хөгжиж буй олон улс орныг хамарсан 2008 оны хүнсний хямрал нь олон улсын зах зээлийн үнээс шалтгаалж бий болсон тул импортлогдсон тогтворгүй байдал байсан. 1943 болон бусад олон жилд гарсан Бенгалын өлсгөлөн нь ашиг хонжоо хайсан үйлдлүүдээс хамаарч гарсан эндоген тогтворгүй байдал байв (Sen, 1977, 1986). Мөн 1974 онд Энэтхэгт гарсан өлсгөлөн нь зах зээлийн буруу төсөөллөөс үүдэн үймсэн ард түмэн хүнсний нөөцийг их хэмжээгээр худалдан авч, үүнээс хамаарч нөөцийн бодит хомсдолд орсон эндоген тогтворгүй байдал байжээ (Ravallion, 1987).

**1.3. Үнийн тогтворгүй байдлын үр дагавар:**

Үнэ тогтворжуулах бодлогууд ихэвчлэн хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд тавигддаг нь эдгээр бүтээгдэхүүний улс орны микро, макро төвшинд

үзүүлдэг нөлөөлөл их байдагтай холбоотой. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн савлагаа нь хэд хэдэн сөрөг нөлөөг тухайн улсад үзүүлж байдаг. Хөгжиж буй улсын дотоодын зах зээл дээрх үнийн хэт хэлбэлзэл нь хүнсний хангалт, хүнсний аюулгүй байдалд (бүтээгдэхүүний үнэ өссөнөөр ядуу өрхүүд хүнсний хэрэглээгээ бууруулах шаардлагатай болно) муугаар нөлөөлж, дотоодын инфляцийг нэмэгдүүлж, ногоон хувьсгалыг (үнэ тогтворгүй нөхцөлд үйлдвэрлэгчид хөрөнгө оруулалт хийхээ хойшлуулдаг) удааширахад нөлөөлнө. Эдгээр нь эргээд нийт эдийн засгийн хөгжилд саад учруулдаг (Timmer, 1988; World Bank, 2007). Зарим тохиолдолд үнийн тогтворгүй байдал нь улс төр болон макро эдийн засгийн тогтворгүй байдлыг бий болгодог. Үнийн хэт хэлбэлзэл, инфляцийн өсөлтөөс хамаарч ард иргэдийн амьдрал доройтох, хөдөө аж ахуй эрхлэгчдийн аж байдал муудах, нийт ард иргэд цалин тэтгэмжийг өсгөхийг шаардах болж, улмаар зарим тохиолдолд улс төрийн тэмцлийг өрнүүлж, засгийн газрын үйл ажиллагааг зогсоохыг оролдох явдлууд гардаг. Иймд аль ч улсын засгийн газар нь иргэдээ өлсгөлөнд нэрвэгдүүлж, хямрал бий болох аюулаас сэргийлэх зорилгоор үнийг тогтворжуулахад тодорхой зохицуулалтыг хийсээр иржээ (Timmer, 1988).

Олон улсын зах зээл дээр хүнсний бүтээгдэхүүний үнэ тогтворгүй байх нь хөгжиж буй улсуудад олон талаар нөлөөлдөг ба сүүлийн жилүүдэд улам өрнөөд буй дэлхийн дулаарал, дэлхийн үр тарианы нөөцийн бууралт, био-эрчим хүчний эрэлт зэрэг нь үнийн хэлбэлзэл цаашид ч үргэлжлэхийг анхааруулж байна. Олон улсын энэхүү байдал нь хөгжиж буй улсуудын дотоодод үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн үнийг улам тогтворгүйжүүлж, импортлогч улсуудын хувьд валютын ханш нь суларч, төлбөрийн тэнцэл нь доройтох сөрөг нөлөөллийг бий болгоно. Хамгийн аюултай нь дотоод болон олон улсын зах зээл дээрх үнийн тогтворгүй байдал нь цаашдын тогтворгүй байдлуудыг бий болгодог гинжин урвал юм (Galtier, 2013). Тухайлбал, эдгээр нь хөдөө аж ахуйд оруулах хөрөнгө оруулалтыг бууруулна, ингэснээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь цаг уураас ихээхэн хамааралтай хэвээр үлдэж үнийн урамшууллын механизмд мэдрэг бус болно, өрх гэрүүд болон улс ороны өөрийгөө тэтгэх чадвар сулрана, улмаар энэ нь дотоодын зах зээлийг хумьж, үнэ таагүй нөхцөлд экспортыг бууруулах сөрөг нөлөө үзүүлдэг байна.

#### **1.4. Үнэ тогтворжуулах бодлогын зорилго, үр нөлөө:**

Үнэ тогтворжуулах бодлогуудын гол зорилго нь үнийн тогтворгүй байдлыг багасгах, эсвэл түүний үр нөлөөг арилгах явдал юм. Энэхүү 2 зорилгын аль

нэгэнд эсвэл хоёуланд нь чиглэсэн бодлогуудыг ч авч хэрэгжүүлэх нь бий. Зарим судлаачдын зүгээс үнэ тогтворжуулалтын бодлогууд нь ихэвчлэн үнийн хэлбэлзлийн үр дагаварт илүү анхаарал тавьдаг, харин үнийн тогтворгүй байдлын уг үндэсийг арилгахад чиглэж чаддаггүй бөгөөд энэхүү байдал нь үнийн тогтворгүй байдлыг цаашид ч бий болгож байдаг хэмээн шүүмжилдэг (Galtier, 2013; Peng, 1991).

### **1.5. Үнэ тогтворжуулалтын аргууд:**

Эдгээрийг үндсэнд нь 3 ангилалд багтааж болно (Peng, 1991). Үүнд: зах зээл рүү нийлүүлэх үйлдвэрлэлийн хэмжээнд нөлөөлөх, үйлдвэрлэгч болон хэрэглэгчдийн хүлээн авч буй үнийг татаас, татварыг хэрэглэн тогтворжуулах, зах зээлийн үйл ажиллагааг хөндөхгүйгээр үйлдвэрлэгчийн орлогыг тогтворжуулах зэрэг нөлөө бүхий хөтөлбөрүүд улс орнуудад хэрэглэгддэг.

○ *“Үйлдвэрлэлийн урсгал”-аар дамжуулан үнэ тогтворжуулах аргууд*  
Эдгээрээс “buffer stock” буюу нөөц бүрдүүлэх арга нь удаан хадгалж болох, муудахгүй хүнсний бүтээгдэхүүн дээр хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга юм. Гол агуулга нь ургац хураалт, үйлдвэрлэл ихтэй, үнэ багатай жилдээ бүтээгдэхүүний тодорхой хэсгийг нөөцлөөд үнэ өссөн үед нь зах зээлд нийлүүлнэ. Улсын нөөцийн энэхүү хөтөлбөр нь үнийн хэлбэлзлийг бууруулж болох ч үйлдвэрлэгчийн орлогын тогтворгүй байдлыг тэр бүр багасгаад байдаггүй. Уг хөтөлбөрийн амжилтын үндэс нь ямар бүтээгдэхүүнийг хадгалах, үнийн ирээдүйн таамаглал нь зөв байх, нөөцийн хөтөлбөрийн зардал нь төсөвт хэт их дарамт учруулахгүй байх явдлууд юм.

Мөн импорт, экспортын хэмжээнд хяналт тавих замаар олон улс орнууд дотоодын зах зээлийн үнийг тогтворжуулах арга бий. Тухайлбал, АНУ нь импортын үхрийн махны хэмжээнд квот тавьснаар дотоодын малчдын орлогыг нэмэгдүүлэх г.м.

○ *Үнийн зохицуулалт хийх аргууд*

Уг бодлогын хувьд зорилтот тогтвортой үнэ, эсвэл үнийн хүрээг урьдчилан тогтоож нийтэд зарладаг. Хэрэв зах зээлийн үнэ нь зорилтот үнээс доогуур тогтвол үйлдвэрлэгчдэд зорилтот үнэ, бодит үнэ хоёрын зөрүүгээр татаас олгоно. Хэрэв үнэ нь зорилтот төвшнөөс дээш тогтвол борлуулалтаас татвар авч, нөөц санг бүрдүүлнэ. Өмнөх тохиолдолд татаас нь энэхүү нөөц сангаас олгогддог. Энэ арга нь богино хугацааны мөчлөгийн үнийн хэлбэлзлийг арилгах, эсвэл багасгах нөлөөтэй. Хэрэв зорилтот үнийн хүрээг



зааж өгсөн бол үнийн хэлбэлзэл уг хүрээнд байгаа нөхцөлд ямар нэг татаас, татвар авагдахгүй, нөөцийн сангийн үйл ажиллагаа явагдахгүй юм. Иймээс улсын нөөцийг биет хэлбэрээр бүрдүүлэх өмнөх аргатай харьцуулахад энэхүү аргын төсөвт үзүүлэх дарамт бага, өөрөө өөрийгөө санхүүжүүлээд явах боломжтой. Гол нь зорилтот үнэ, эсвэл үнийн хүрээг зөв тогтоох нь энэ аргыг амжилттай хэрэгжих үндэсийг бүрдүүлдэг.

Шинэ Зеланд, Австраль улсуудад борлуулах цэг, үйлдвэрлэгчид төлөх төлбөр гэсэн 2 тогтолцоог хэрэгжүүлж байсан. Эхний тогтолцооны хувьд хэрэв үйлдвэрлэгчийн үнэ нь тогтворжуулалтын үнээс доогуур байвал малыг мал нядалгаанд илгээх, эсвэл нядлах үед нь малчдад нөөцийн сангаас төлбөр төлнө. Хэрэв үнэ нь тогтворжуулалтын үнээс илүү гарвал малын толгой бүрээс нядалгаанд орж, борлуулагдах үед нь шимтгэл авагддаг байна. Харин Австралид хэрэглэсэн үйлдвэрлэгчид төлөх төлбөр тогтолцооны хувьд бодит борлуулалт бус малын үйлдвэрлэлд суурилан малчдад төлбөр төлдгөөрөө ялгаатай. Уг систем нь 2 зорилготой: богино хугацааны шийдвэр гаргалтаас нь үл хамааран үйлдвэрлэгчид нь нөөцийн сангаас төлбөр авах боломжтой байх; тухайн салбарт засгийн газраас шууд туслалцаа үзүүлэх боломжийг бүрдүүлсэн удирдлагын механизмтай байх явдал юм.

### ○ *Алдагдлын төлбөр*

Их Британи, Канад зэрэг улсууд үхрийн мах болон зарим хөдөө аж ахуйн барааны үнийг тогтворжуулахдаа алдагдалд төлбөр төлөх зарчмыг баримталдаг. Засгийн газар нь зах зээлийн клирингийн үнэ болон малчдад баталгаа болгосон үнэ хоёрын зөрүүгээр төлбөр төлөх үүрэг хүлээдэг. Ингэснээр махыг биетээр нөөцлөх арга шиг хадгалах, түгээх, устгах зардлууд гарахгүй. Хэрэглэгчид бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдсэнээс үүдэх бага үнээр хэрэгцээгээ хангах сайн талтай. Нийлүүлэлтэнд хяналт тогтоох аргуудыг бодвол хөдөө аж ахуйг дэмжихэд гарсан зардал нь улсын төсөвт ил тод тусгагдана. Хэрэв алдагдлын төлбөр нь өсөн нэмэгдэх (өндөр орлоготойгоос их татвар авах зарчимтай) татварын орлогоор санхүүждэг бол бага орлоготой бүлгүүд өндөр орлоготой бүлгүүдээс авах татварын зардлын ач тусыг дам байдлаар хүртэж байна гэсэн үг юм.

### ○ *Үнэлгээ (Appraisal)*

Өгөгдсөн засгийн газрын зардлын нөхцөлд хувийн секторын ажиллуулж буй агуулахуудад татаас өгөх замаар зах зээлийн үнийг тогтворжуулах нь нэлээд үр ашигтай арга юм. Түүхийнхээ янз бүрийн үе шатанд улс орнууд дээрх аргуудыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний шинж чанар, тухайн улсад үзүүлэх ач холбогдол, эдийн засгийн голлогч бодлогоосоо хамааруулан ашиглаж ирсэн. Эдгээрт давуу болон сул талууд байсан бөгөөд үнэ

тогтворжуулалтын дэвшүүлэн тавьсан зорилгодоо хүрсэн эсэх, шууд болон дам ямар нөлөөг үйлдвэрлэгчид, хэрэглэгчид болон зах зээлд үзүүлдэг вэ гэдэг талаар судлаачид өнөөг хүртэл санал зөрөлдсөөр иржээ.

**1.6. Үнэ тогтворжуулалтын олон улсын зарим туршлага**

**Энэтхэгийн үнэ тогтворжуулах сан**

Энэтхэг улсын засгийн газар нь 2003 оны 04 сараас 2013 оны 04 сар хүртэл цай, кофе, каучук, тамхины ургамал гэсэн 4 төрлийн газар тариалангийн бүтээгдэхүүний үнийн уналтаас үүдсэн тариаланчдын санхүүгийн хүндрэлтэй байдлыг бууруулах үүднээс “Үнэ тогтворжуулах сан” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн.

Уг хөтөлбөрийн гол зорилго нь дээрх газар тариалангийн бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнэ нь тогтоосон түвшингээс буурсан тохиолдолд хөтөлбөрт хамрагдах тариаланчдад санхүүгийн туслалцаа үзүүлэх, урт хугацааны тогтвортой байдлыг тариаланчдад бий болгох, тэдний эрх ашгийг хамгаалах явдал юм. Хөтөлбөрийн онцлогийг тоймлон харуулбал:

**Хүснэгт 1.1 Энэтхэгийн үнэ тогтворжуулах сангийн онцлог**

<i>Сангийн хөрөнгө бүрдэлт</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Сангийн үндсэн хөрөнгө 5 тэрбум рупи</li> <li>- Засгийн газрын нэг удаагийн хувь нэмэр 4,83 тэрбум рупи</li> <li>- Тариаланчдын нэг удаагийн хувь нэмэр 171,2 сая рупи (342 мянган тариаланчдын хураамж)</li> </ul>
<i>Оролцогчдод тавигдах шаардлага</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Нийт 1,3 сая тариаланчдаас нэн тэргүүнд оролцох шаардлагатай 342 мянган тариаланчид (4 хүртэл га газартай тариаланчид багтсан) орох боломжтой</li> <li>- Хөтөлбөрт оролцох хураамж болох 500 рупи төлөх</li> <li>- Аль 1 банкинд Үнэ тогтворжуулах сангийн данс нээлгэх</li> </ul>
<i>Үнийн хүрээ, үйлчлэх хүрээ</i>	<ul style="list-style-type: none"> <li>- 4 төрлийн бүтээгдэхүүний хувьд адилхан 40% байна</li> <li>- Тухайн бүтээгдэхүүний сүүлийн 7 жилийн олон улсын зах зээлийн үнийн хөдөлгөөнт дундажад суурилан үнийн хүрээг тогтооно</li> <li>- Үнийн доод хүрээ нь ОУ-ын зах зээлийн</li> </ul>

	<p>дундаж үнийн -20%, дээд хүрээ нь ОУ-ын зах зээлийн дундаж үнийн +20%</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дотоодын үнийг Үнийн хүрээнд харьцуулах замаар Өсөлттэй, Хэвийн, Уналттай жилүүд гэж ангилна             <ul style="list-style-type: none"> <li>○ <i>Өсөлттэй жил</i>: дотоодын үнэ нь үнийн дээд хүрээнээс их</li> <li>○ <i>Хэвийн жил</i>: дотоодын үнэ нь үнийн дээд, доод үнийн хүрээнд багтаж байх үе</li> <li>○ <i>Уналттай жил</i>: дотоодын үнэ нь үнийн доод хүрээнээс бага байх үе</li> </ul> </li> </ul>
<p><i>Сангийн хуримтлал болон зарцуулалт</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>- <i>Өсөлттэй жил</i>: Тариаланч 1000 рупи дансанд хийх ба нөхөн төлбөр авахгүй</li> <li>- <i>Хэвийн жил</i>: Засгийн газар 500 рупи, тариаланч бүр 500 рупи дансанд хийх ба нөхөн төлбөр авахгүй</li> <li>- <i>Уналттай жил</i>: Засгийн газар 1000 рупи дансанд хийх ба тариаланч бүр 1000 хүртэлх рупиг нөхөн төлбөр хэлбэрээр авч болно</li> </ul>

Үнэ тогтворжуулах сангийн үндсэн хөрөнгө нь Засгийн газрын төрийн дансанд жилийн 8%-ийн хүүтэйгээр байршдаг бөгөөд сангаас зарцуулалт хийхдээ үндсэн хөрөнгөнд хүрэлгүйгээр жилийн хүүний орлогыг л ашигладаг байна. Энэхүү хүүгийн орлого нь Энэтхэгийн хөгжлийн банк болох Хөдөө Аж Ахуйн Хөгжлийн Үндэсний Банкны удирдлага дор ажилладаг итгэлцлийн сан руу шилжиж, улмаар үнэ тогтворжуулах сангийн үйл ажиллагаанд зарцуулагддаг. Уг итгэлцлийн сангийн үйл ажиллагааг Энэтхэгийн төрийн аудитор хянах ба 5 жил тутамд үйл ажиллагаанд үнэлэлт өгдөг.

Энэтхэгийн энэхүү хөтөлбөр 2013 онд амжилттай хэрэгжиж дуусахад Худалдааны яамнаас “Тодотгосон үнэ тогтворжуулах сан”-ийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. Өмнөх хөтөлбөртэй адил бөгөөд зарим дутагдалтай талыг нь сайжруулсан байна. Үүнд:

- Цай, кофе, каучук, тамхины ургамал дээр cardamom хэмээх ургамлыг нэмсэн
- Олон улсын зах зээлийн сүүлийн 5 жилийн хөдөлгөөнт дунджид суурилан үнийн хүрээг тогтоох
- Өмнөх хөтөлбөрт хамрагдаж байсан тариаланчид хураамж төлөлгүйгээр шинэ хөтөлбөрт шууд шилжих боломжтой

- Өмнөхтэй адил хэвийн болон өсөлттэй жилд тариаланчид нөхөн төлбөр авахгүй. Зөвхөн уналттай жилд шаардлага хангасан тариаланчид тариалан эрхэлж буй 10 га хүртэлх талбайд га тутамд 12,000 рупиг нөхөн төлбөрт авч болох бөгөөд нөхөн төлбөрийн дээд хэмжээ 1 тариаланчийн хувьд 60,000 рупигээс хэтрэхгүй. Хэрэв уналттай жил үргэлжилбэл дараагийн жил нь нөхөн төлбөрийн хэмжээ 15%-иар өснө. Хэрэв 5 жилийн хугацаанд уналттай жил тохиолдохгүй бол нөхөн төлбөр болох 12,000 рупиг (дээд хязгаар нь 60,000 рупи) нэхэмжлэх боломжгүй.
- Тариаланч бүр зураг бүхий АТМ дебит карттай болсноор өмнөх хөтөлбөрийн үед банкинд дугаарлах, бичиг баримт бүрдүүлэх зэрэг аль аль талд учирч байсан хүндрэлүүдийг шийдвэрлэсэн.

### ***Канадын хөдөө аж ахуйн орлого тогтворжуулах хөтөлбөр***

Уг хөтөлбөр нь 2007 оноос Онтарио мужийн санаачлагаар батлагдан хэрэгжиж эхэлсэн. Энэ нь урт хугацааны туршид хэрэгжих фермерийн эрсдлийн удирдлагын хэрэгсэл бөгөөд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орлогын бага болон их хэмжээний бууралтаас хөдөө аж ахуй эрхлэгчдийг хамгаалах зорилготой юм. Хөтөлбөрийн онцлог нь орлогыг тогтворжуулах болон гамшгийн үеийн тусламжийг хамтад нь цогцоор нь шийдсэн явдал юм.

Гол агуулга нь орлогын алдагдлыг засгийн газар болон хөдөө аж ахуй эрхлэгчид хувааж төлөх ба хэрэв орлого бага хэмжээгээр буурсан үед засгийн газар болон хөтөлбөрт оролцогчид ижил хэмжээгээр уг алдагдлыг нөхнө; харин алдагдлын хэмжээ ихэсвэл засгийн газраас нөхөн төлөх төлбөрийн хувь 4 дахин ихсэх боломжтой. Хөтөлбөрт оролцогчид нь жил бүр оролцооны хураамжийг төлөх ба тухайн жилийн орлого (фермерийн борлуулалтаас зөвхөн үйл ажиллагаатай холбоотой зардлуудыг хассан дүн буюу үйлдвэрлэлийн маржин) нь өмнөх 5 эсвэл 3 жилийн орлогын дунджаас бага тохиолдолд орлогын алдагдал үүссэн хэмээн үзэж нөхөн төлбөр олгодог байна.

Уг хөтөлбөрийн хэрэгжилтийг Онтарио Агрикорп хэмээх Онтарио мужийн хөдөө аж ахуйн салбарт эрсдлийн удирдлагын хөтөлбөрүүд, хөдөө аж ахуйн даатгалыг хэрэгжүүлдэг Хатан хааны нэрэмжит агентлаг хангаж ажилладаг. Энэхүү байгууллага нь хөтөлбөрт оролцогчдын бүртгэл, тэдгээрийн фермерийн орлогын тооцоо, хураамж, нөхөн төлбөрийн хэмжээ зэргийг тооцоолж, олгох ажлыг зохион байгуулдаг.

Хөтөлбөрт оролцох фермерүүдэд нь Канад улсад фермерийн аж ахуйг дор хаяж тасралтгүй 6 сар эрхэлсэн, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бүрэн циклээр гүйцэтгэдэг, фермерийн орлогын татвар төлж, тайлангаа Канадын Орлогын Агентлагт цаг хугацаанд нь гаргаж өгдөг байх ёстой гэсэн шаардлага тавьдаг. Фермер нь татвар төлдөг хуулийн этгээд болох хувиараа эрхлэх аж ахуй, хязгаарлагдмал нөхөрлөл, корпорац, хоршоолол хэлбэртэй байж болно. Оролцогчид нь нөхөн төлбөр авах түвшингөөсөө хамаарч жилийн хураамжаа төлөх боломжтой. Үүнд 3 төрлийн хамрах түвшин бий:


- *Дээд түвшин:* тухайн жилийн нийт маржины бууралтын 70 хүртэлх хувийг даатгах. Энэ тохиолдолд жилийн хураамж нь (100% х өмнөх таван жилийн үйлдвэрлэлийн маржины дундаж х 0.45%)
- *Дунд түвшин:* тухайн жилийн нийт маржины бууралтын 66.5 хүртэлх хувийг даатгах. Энэ тохиолдолд жилийн хураамж нь (85% х өмнөх таван жилийн үйлдвэрлэлийн маржины дундаж х 0.45%)
- *Доод түвшин:* тухайн жилийн нийт маржины бууралтын 56 хүртэлх хувийг даатгах. Энэ тохиолдолд жилийн хураамж нь (70% х өмнөх таван жилийн үйлдвэрлэлийн маржины дундаж х 0.45%)

Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны зардалд оролцогч бүрээс жилд 55 канад долларыг суутгадаг.

Хөтөлбөрөөс хүртэх нөхөн төлбөрийн хувьд тухайн жилийн маржин нь өмнөх 5 жилийн дундаж маржинаас доогуур болбол тухайн оролцогчийн төлсөн хураамж, сонгосон нөхөн төлбөрийн түвшингөөс хамаарч олговрыг дараах үеээр олгоно:

- *Нэгдүгээр үе:* Тухайн жилийн маржин нь өмнөх 5 жилийн дундаж маржинаас 15%-иар буурахад маржины алдагдлын 50%-ийг Засгийн газар төлнө.
- *Хоёрдугаар үе:* Тухайн жилийн маржин нь өмнөх 5 жилийн дундаж маржинаас 15-30%-ийн уналттай үед маржины алдагдлын 70%-ийг Засгийн газар төлнө.
- *Гуравдугаар үе:* Тухайн жилийн маржин нь өмнөх 5 жилийн дундаж маржинаас 30%-иас дээш уналттай үед маржины алдагдлын 80%-ийг Засгийн газар төлнө.
- *Дөрөвдүгээр үе:* Тухайн жилийн маржин нь сөрөг гарвал уг сөрөг дүнгийн 60%-ийг Засгийн газар төлнө (Зураг 3)

**Зураг 1.3 Канадын орлого тогтворжуулах хөтөлбөрийн засгийн газрын оролцоо**



Эх сурвалж: “Канадын хөдөө аж ахуйн орлого тогтворжуулах хөтөлбөрийн гарын авлага”,

15-р тал (Canada-Ontario Initiative, 2007)

### **Тайваны хөдөө аж ахуйн бодлого**

Дэлхийн II дайны дараах Тайваны ХАА-н бодлого нь 1969 он хүртэлх болон түүнээс хойших гэсэн 2 үндсэн үе шаттай байв. Эхний үед үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсний бүтээгдэхүүний бодит үнийг технологи, институцийн шинэ санаачлагын үндсэн дээр бууруулахад ХАА-н бодлогууд нь чиглэж байсан. Харин 1969 оноос хойш дотоодын зах зээлд ХАА-н болон ХАА-н бус салбарын орлогын ялгаа ихэссэн, олон улсын зах зээл дээр Тайваны аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт эрс өссөнөөр гадаад худалдааны тэнцэл нь эерэг болж, улмаар гаднаас импортлох хямд үнэтэй ХАА-н бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэнээс дотоодын ХАА эрхлэгчдэд хүнд цохилт болсон. Иймд үндэсний ХАА-н салбарыг хөгжүүлэх, ХАА эрхлэгчдийн орлого, баялагийг нэмэгдүүлэх, дотоодын хүнсний хэрэгцээгээ өөрсдөө хангадаг болох зорилгоор засгийн газраас нь төрөл бүрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ ХАА-н хөгжлийн хуулийг 1973 онд батлан мөрдсөн байна. Үнэ болон орлогыг тогтворжуулах бодлогуудын гол хэрэгслүүд нь үнийг дэмжих, үнэ тогтворжуулах, шууд төлбөр болон зардалд олгох татаас зэрэг байв. Эдгээрийг дараах хүснэгтэнд нэгтгэн харуулав.

Хүснэгт 1.2 Тайваны ХАА-н бодлогын ерөнхий бүтэц

№	Бодлогын хүрээ	Зорилго	Гол төсөл/арга хэмжээнүүд
1	Бүтцийн бодлого	<ul style="list-style-type: none"> <li>• Фермүүдийн хэмжээг өргөжүүлэх</li> <li>• Фермерүүдийн хоршилтыг дэмжих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• ХАА-н газрын шинэчлэлийн хөтөлбөрийн 2 дахь үе шат</li> <li>• Фермийн газрыг худалдан авах хөтөлбөр</li> <li>• Бүсийн төлөвлөлтийн хөтөлбөр</li> <li>• Цөм фермерийн хөтөлбөр</li> <li>• Хөдөөгийн аж үйлдвэржилтийг дэмжих хөтөлбөр</li> </ul>
2	Үйлдвэрлэлийн бодлого	<ul style="list-style-type: none"> <li>• ХАА-н үйлдвэрлэлийн бүтцийг зохицуулах</li> <li>• Үр ашгийг нэмэгдүүлэх</li> <li>• ХАА-н дэд бүтцийг сайжруулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Цагаан будааны тариалангийн талбайг хамгаалах хөтөлбөр</li> <li>• Судалгаа</li> <li>• Усжуулалт болон газрын нөөцийн хөтөлбөр</li> <li>• Фермийн техник, технологийг шинэчлэх хөтөлбөр</li> <li>• Хөдөөд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалт</li> </ul>
3	Үнэ болон орлогын бодлого	<ul style="list-style-type: none"> <li>• Үнийг тогтворжуулах болон дэмжих</li> <li>• Фермер өрхийн орлогыг нэмэгдүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Цагаан будаа, жижиг үр тариа, сахар болон гол тарианы үнийг дэмжих хөтөлбөрүүд</li> <li>• Импортын үр тарианы үнийг тогтворжуулах хөтөлбөр</li> <li>• Малын даатгал</li> <li>• ХАА-н хөгжил, зээлийн хөтөлбөр</li> <li>• Хилийн арга хэмжээ</li> <li>• Шууд төлбөр</li> </ul>
4	Маркетингийн	<ul style="list-style-type: none"> <li>• Маркетингийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• ХАА-н маркетингийн</li> </ul>

	бодлого	сувгуудыг оновчтой болгох <ul style="list-style-type: none"> <li>• Хүнсний бүтээгдэхүүний чанарыг сайжруулах</li> </ul>	хууль <ul style="list-style-type: none"> <li>• Хүнсний бүтээгдэхүүний боловсруулалтыг хөгжүүлэх хөтөлбөр</li> <li>• Хамтарсан маркетингийн хөтөлбөр</li> <li>• Бөөний захын шинэчлэлийн хөтөлбөр</li> </ul>
5	Хөдөөгийн амьдралын бодлого	<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөөгийн тосгодын хүрээлэн буй орчины хүчин зүйлсийг сайжруулах</li> <li>• ХАА эрхлэгчдийн баялагийг нэмэгдүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Фермерүүдийн эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр</li> <li>• Хөдөөгийн тосгодыг дахин зохион байгуулах хөтөлбөр</li> <li>• Фермерүүдийн дэлгүүр, төвүүдийг байгуулах</li> </ul>

Эх сурвалж: Ts. Peng (1991) "Price stabilization measures and their impacts", 102-р тал

Эдгээрээс үнэ болон орлого тогтворжуулах хөтөлбөрүүдийг авч үзвэл ХАА-н гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах зорилгоор Тайваны засгийн газраас гурил, шар буурцаг, эрдэнэ шишийн нөөцийн сан; жижиг ХАА эрхлэгчдэд бүтээгдэхүүнээ боломжийн үнээр худалдахад нь туслах зорилгоор дотоодын зах зээлийг тогтворжуулах сан зэргийг байгуулжээ.

а. *Импортын бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах сан:* Хүнсний тос, гурил, малын тэжээлийн үйлдвэрлэлд хэрэглэгддэг түүхий эдийн 90 гаруй хувийг импортолдог байсан тул эдгээрийн олон улсын зах зээл дээрх үнийн хэлбэлзэл нь дотоодод үйлдвэрлэх хүнсний бүтээгдэхүүний үнийг ихээхэн хэлбэлзэхэд хүргэж байв. Иймд зарим жижиг үр тарианд импортын квот, засгийн газраас олгосон лицензээр худалдан авах, түүхий эдүүдийг багцлан "нэгдсэн импортын үнэ"-ийн тогтолцоонд багтааж эдгээрийг худалдан авагч дотоодын хэрэглэгчид нь олон улсын барааны зах зээлийн үнэд суурилан тогтоосон тогтворжсон үнийг төлөх боломж олгосон.

б. *Үйлдвэрлэгчийн маркетингийн үнийг тогтворжуулах сан:* Үр тарианы үнийг бодвол гахай, загасны мах, хүнсний ногоо, жимсний үнэ нь илүү хэлбэлзэлтэй байдаг тул жижиг фермерүүд бүтээгдэхүүнээ ашигтай худалдахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор фермерүүдийн холбоо, маркетингийн хоршоодын оролцоотойгоор эдгээр бүтээгдэхүүнд зориулан хамтарсан маркетингийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Эдгээр холбоодын зорилго нь хамтарсан маркетинг хийх замаар маркетингийн нэгжийн зардлыг бууруулах, үйлдвэрлэгчдийн хувьд боломжийн үнээр бүтээгдэхүүнээ худалдаалах, их хэмжээний борлуулалт хийн үйлдвэрлэгчид



болон худалдаачдын хооронд бат бөх харилцаа үүсгэх явдал байв. Фермерүүдийн худалдах үнийг тогтворжуулахын тулд төрөл бүрийн бөөний худалдааны захуудын үнийн дунджид суурилсан баталгаат үнийг тогтоосон. Уг хөтөлбөрт оролцогч фермерүүд тогтворжуулалтын санд хураамж төлж, шаардлагыг нь хангасан тохиолдолд баталгаат үнэд хамрагддаг. Энэхүү сан нь засгийн газрын дэмжлэгтэй бие даан санхүүжилтээ шийдвэрлэдэг бөгөөд зах зээлийн зуучлагчид, фермерүүдийн холбоо нь сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг бүрдүүлж, хувь нэмэр оруулдаг байна.

в. *Шууд төлбөр төлөх хөтөлбөр*: Баталгаат өндөр үнэ, цагаан будааны дотоодын хэрэглээний буурсан, экспортын квоттой байсан зэргээс хамаарч цагаан будааны үйлдвэрлэлийн илүүдэл бий болсон. Иймд 1980-д онд тариаланчдын эрх ашгийг хохироолгүйгээр цагаан будааны тариалалтыг бууруулж, тариалангийн талбайд эрдэнэ шиш мэтийн эрэлт ихтэй өөр ургамлын тариалалтыг дэмжих бодлого баримталжээ. Засгийн газраас цагаан будааны оронд эрдэнэ шиш, шар буурцаг, сорго зэргийг тариалах санаачилга гаргасан тариаланчдад өөр ургамал тарихтай холбоотой гарах эрсдлийг нь бууруулах зорилгоор биет төлбөр болох цагаан будааг олгох болов. Үүнд: дээрх 3 ургамлыг тариалбал 1000 кг цагаан будаа, хүнсний ногоо, жимс таривал 1500 кг, тариалангийн талбайд ургамал тарилгүй нөөцөлвөл 1500 кг цагаан будааг нөхөн төлбөр байдлаар олгож байв.

г. *Зардалд татаас олгох хөтөлбөр*: Үйлдвэрлэлийн зардал болон санхүүгийн дарамтыг бууруулахын тулд ХАА-н татварын системийг боловсронгуй болгосон. Мөн ХАА-н үйлдвэрлэлд гарах эрчим хүчний зардлын тодорхой хэсгийг засгийн газраас татаас хэлбэрээр хөнгөлж, фермерүүдийг шинэ технологи нэвтрүүлэх, байгаа нөөцөө үр ашигтай ашиглах байдлыг нь дэмжих зорилгоор зээлийн шинэ системийг хэрэгжүүлжээ. Ингэснээр тодорхой хөтөлбөрийн хүрээнд засгийн газраас бага хүүтэй, уян хатан нөхцөлтэй зээлийг фермерүүдэд олгож байв.

Тайваны үнэ тогтворжуулах хөтөлбөрүүдийн онцлог нь цагаан будаанаас бусад үр тариа, хүнсний ногоо, жимсний үнийг тогтворжуулах хөтөлбөрүүд нь засгийн газраас эхэлж санаачилсан ч аажмаар санхүүгийн хувьд бие даасан байдалд шилжсэн явдал юм. Эдгээрийг ихэвчлэн фермерүүдийн хоршоо, холбоод удирдан явуулдаг байна.

е. *Үнэ тогтворжуулалтын арга механизмууд, тэдгээрийн уялдааг хангах нь*

Эрдэмтэд, судлаачдын үзэж байгаагаар хүнсний бүтээгдэхүүний үнийн тогтворгүй байдал нь орлого болон худалдан авах чадварыг доройтуулж, хүнсний аюулгүй байдал, хүнсний үйлвэрлэлд оруулах хөрөнгө оруулалтын

бууралт, макро эдийн засгийн доройтол зэрэг хөгжлийн асуудлуудыг үүсгэхээс гадна улс төрийн тогтворгүй байдалд ч хүргэх аюултай билээ. Иймд үнийн тогтворгүй байдлыг хоёр хандлагаар шийдвэрлэх боломжтой. Үүнд: нэгдүгээрт үнийг тогтворжуулах, хоёрт орлого болон худалдан авах чадварыг бууруулж буй үнийн тогтворгүй байдлын нөлөөллийг бууруулах зэрэг нь багтана. Эдгээр хандлага нь зах зээлийг хөгжүүлэх болон төрийн оролцоог хангах арга замуудын аль алиныг ашиглан хэрэгжүүлэх боломжтойгоороо онцлог юм. Дараах матриц нь үнэ тогтворжуулалтын зорилго, хэрэгжүүлэх стратеги болон арга замуудыг нэгтгэн харуулжээ:

**Хүснэгт 1.3 Үнэ тогтворжуулалтын стратегийн ABCD матриц**

<b>Зорилго</b> <b>Арга зам</b>	<b>Үнэ тогтворжуулах</b>	<b>Үнийн тогтворгүй байдлын нөлөөг бууруулах</b>
<b>Зах зээлийн хөгжил</b>	А стратеги	В стратеги
<b>Төрийн оролцоо</b>	С стратеги	Д стратеги

Эх сурвалж: F. Galtier (2013) “Managing food price instability in developing countries: A critical analysis of strategies and instruments”, (31-р тал)

**А стратеги** нь үйлдвэрлэл, худалдаа болон хэрэглээг үнэд мэдрэг болгох замаар үнийн тогтворгүй байдлыг зах зээлийн оролцогчид үнийн арбитражаар дамжуулан засварлах боломжийг олгоно. Арбитражийг хугацаа (худалдах, худалдан авах цаг хугацааны сонголт), байршил (хаана худалдах, худалдан авах), бүтээгдэхүүн хооронд (тариаланчид ямар ургамал тарих, өрх гэрүүд ямар бүтээгдэхүүн авахаа сонгох) болон бүтээгдэхүүний технологи хоорондын (тариаланчид, малчид ямар технологийн дэвшил хэрэглэх, тэдгээр нь байгалийн гамшигт хэр мэдрэг байх зэрэг) сонголтоос хамаарч хийнэ. Эдгээр сонголт, шийдвэрүүд нь үнэд суурилан хийгдэх тул нэн тэргүүнд зах зээлд оролцогчдыг үнийн хөдөлгөөний мэдээллээр хангах “Зах зээлийн мэдээллийн систем” зайлшгүй шаардлагатай. Гэхдээ мэдээллээс гадна дэд бүтэц, бордоо, санхүүжилт авах боломж зэрэг бусад хүчин зүйлс нь зах зээлд оролцогчдын шийдвэрт нөлөөлж байдаг тул А стратегийн хэрэгслүүдийг: хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орцын хангалт (үр, бордоо, услалтын систем, тоног төхөөрөмж, зээл, зөвлөгөө г.м) болон зах зээлийн дэд бүтэц, институци (тээвэрлэлт, зам, харилцаа холбоо, боловсруулалт, хадгалалтын газрууд,

улирлын зээллэг, зэрэглэл тогтоолт, бирж г.м) гэсэн 2 үндсэн хэсэгт хувааж болно.

**В стратеги** нь үйлдвэрлэгч болон худалдаачдад үнийн эрсдлээс өөрсдийгөө хамгаалах боломжийг олгодог. Хэдийгээр фьючерс нь үнийг тогтворжуулах зорилгогүй боловч үнийн тогтворгүй байдлаас үүдэж орлогоо бууруулахгүй байхад тусалдаг нэг ёсны даатгал юм. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд үр тариа хураалтын эрсдэл нь үнийн эрсдэлтэй холбоотой байдаг тул энэхүү стратеги нь тариа хураалтын эрсдлээс даатгах агуулгыг ч өөртөө багтаадаг. Уг стратегийн хэрэгслүүдийг 3 бүлэгт хуваадаг: фьючерс, даатгал (үр тарианы даатгал, цаг агаарын индексжүүлсэн даатгал) болон зээллэг (үйлдвэрлэгч болон хэрэглэгчийн). Эхний 2 бүлэг хэрэгсэл нь үнэ болон үр тарианы хураалтын эрсдлийн эсрэг хэрэглэгддэг урьдчилсан хамгаалалтын үүрэгтэй бол 3 дахь бүлэг хэрэгсэл нь үнийн хэлбэлзэл, хураалт бууралт болсоноос үүдэн гарсан орлогын өөрчлөлтийг зохицуулах зорилгоор ашиглагддаг.

**С стратеги** нь нийлүүлэлт нь эрэлтийг хангаж байхуйцаар үйлдвэрлэл, хадгалалт болон гадаад худалдаанд төрийн зүгээс үзүүлэх оролцоо юм. Тухайлбал, үйлдвэрлэлийн хэмжээг хянах үүднээс зардалд татаас өгөх, эсвэл үйлдвэрлэлийн хэмжээнд хязгаарлалт тогтоож болно. Гадаад худалдааг зохицуулах үүднээс импорт, экспортын хэмжээнд хязгаарлалт тогтоох, татвар авах, татаас өгөх хэрэгслүүдийг ашигладаг. Харин хадгалалтын байдалд нөлөөлөхийн тулд ихэнх улсуудад төрийн нөөцийг бүрдүүлж ашигладаг. Зарим улсуудад хувийн салбарын хөдөө аж ахуйн барааны нөөцөд шууд бус байдлаар зохицуулалт хийх аргууд ч бий.

**Д стратеги** нь өрх гэрүүдийн үнийн өсөлтөөс үүдсэн хүнсний хомсдлыг зохицуулах зорилготой. Энэхүү стратеги нь үнийн хэт өсөлттэй байгаа үед хамгийн эмзэг бүлгийн өрх гэрүүдэд чиглэдэг бөгөөд төрөөс хүнсний бүтээгдэхүүн тараах хэлбэрээр хэрэгждэг. Гэхдээ энэхүү стратегийн хэрэгслүүд нь тарааж буй бараа (бэлэн мөнгө, ваучер, хоол хүнс г.м), зорилго, тусламжийн хэлбэр (чөлөөт тараалт, татаас г.м), шаардлагатай хувь нэмэр (хүлээн авагч өрх гэрүүд хөдөлмөр эсвэл тодорхой хувь нэмэр оруулах шаардлагатай байх, тухайлбал хүүхдээ сургуульд хамруулах г.м), бүтцийн хувьд (эмзэг өрхийг капиталжуулах) болон онцгой тохиолдол хэрэглэгдэж байна уу гэдгээсээ хамаарч ялгаатай байдаг.

Эдгээр стратегийн хүрээнд үнийг тогтворжуулах, үнийн тогтворгүй байдлын үр нөлөөг арилгах зорилгоор янз бүрийн хэрэгслүүдийг дангаар нь хавсарсан хэлбэрээр ашиглаж болдог. Ингэхдээ тухайн хэрэгслүүд нь үнийн тогтворгүй байдлыг бий болгодог дээр дурьдсан 3 шалтгааны алийг арилгах

боломжтой, үнийн тогтворгүй байдал, өрхийн орлого, өрхийн хэрэглээ болон хөрөнгө оруулалтыг хэрхэн өөрчлөх зэргийг нь сайтар харгалзаж үзэх хэрэгтэй юм. Үнэ тогтворжуулах дөрвөн стратегийн хүрээнд хэрэглэгддэг арга хэрэгслүүдийн орлого, хэрэглээ, хөрөнгө оруулалтын алинд илүү нөлөөлдгийг дараах схемээр харуулав.

**Зураг 1.4 Үнэ тогтворжуулах хэрэгслүүдийн үр нөлөө**



Эх сурвалж: F. Galtier (2013) “Managing food price instability in developing countries: A critical analysis of strategies and instruments”, (114-р тал)

Энэхүү схемээс харахад А болон С хэрэгслүүд нь үнэ тогтворжуулах зорилгоор хэрэглэгдэж, үнийн тогтворгүй байдлыг үүсгэж буй 3 гол шалтгаан, үнийн тогтворгүй байдлыг бууруулахад гол анхаарлыг хандуулдаг. Харин В болон D стратегийн хэрэгслүүдийн хувьд үнийн тогтворгүй байдлаас үүдэн гардаг өрхийн орлого, хэрэглээ, хөрөнгө оруулалтын өөрчлөлтүүдийг аль болох багасгах чиглэлд голлон нөлөөлдөг байна. Эдгээрээс В хэрэгслүүдийн нь үнийн тогтворгүй байдлаас хамаарч ХАА эрхлэгчдийн орлого тогтворгүйжих сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн эрсдлийг удирдах санхүүгийн хэрэгслүүд гэдгээрээ онцлог юм. Гэвч эдгээр хэрэгсэл нь хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн улсуудад илүү үр өгөөжөө өгөхөөс биш энэхүү зах зээл нь сул хөгжсөн хөгжиж буй улсуудад богино хугацаанд амжилттай хэрэгжиж чадахгүй билээ. Иймд төрийн тодорхой хэмжээний зохицуулалт бүхий С, D хэрэгслүүдийг зах зээлд тулгуурлан хэрэгжүүлэх А, В хэрэгслүүдтэй зөв хослуулан хэрэглэх шаардлагатай юм.

Үүний гол агуулга нь зах зээлийн жамаараа үнэ харьцангуйгаар өөрөө тогтворждог зөв системд шилжихэд А, В хэрэгслүүд нэн хэрэгтэй боловч, эдгээрийг хөгжүүлж, төлөвшүүлэхэд харьцангуй урт хугацаа шаардлагатай. Иймд эдгээр зах зээлийн хэрэгслүүдийг аажмаар хөгжүүлэх бодлогыг баримтлах явцдаа богино болон дунд хугацаанд төрийн зохицуулалт бүхий үнэ тогтворжуулах хэрэгслүүдийг зохистойгоор хэрэглэх замаар үнийн тогтворгүй байдлаас үүдэх макро, микро эдийн засгийн болон бусад сөрөг үр нөлөөг багасгах нь улс орнуудын хувьд хэрэглэгдэж буй нийтлэг стратеги юм.





**Хүснэгт 2.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд үнэ нь хамгийн их хэлбэлзэлтэй нэр төрлүүд**

Үнийн хэлбэлзэл ихтэй нэр төрөл	Вариацийн коэффициент хувиар
1. Õí í èí ù ì àõ, êã	30,1
2. Yõðèéí ì àõ, êã	30,4
3. Àãóóí ù ì àõ, êã	32,5
4. Àðòè, "Ñì èðí í ô ô ", 0.75è, ääääää	29,7
5. Ì àðãàðéí , "Ñòáí è-í í á", 500 ãð	34,0
6. Àèèì , ø àð, êã	26,8
7. Èóóääí , äí òí í ä, êã	29,4
8. Ì àí æéí , äí òí í ä, êã	43,8
9. Õñ, 1.5è, Àèòàò èò	39,7
10. ßí æóóð òàì òè, "THIS", Ñì èí í ã ñ	32,1
11. ßí æóóð òàì òè, "Àèòáí í àã-:", äí òí í ä	42,9
12. Ýðýãýé í ðí í èò, í í ñí í äääâóó, Õýòää	35,8
13. Ýì ýãýé í í í èóóðáí òàì ò, 46-48 ðàçì áð, "Ãí äü" ÕË, äæäí í áð	33,3
14. Áðð ê, 46-48 ðàçì áð, ýí æéí òèèöðýé, Õýòää	33,7
15. Í í í èóóðáí òàì ò, "Ãí äü" ÕË, õí ø óó çàðòàé, 48-50 ðàçì áð	26,0

2010 оны 1 дүгээр сараас 2013 оны 8 дугаар сарын хооронд үнэ нь хамгийн тогтворгүй байсан 15 нэр төрлөөс хонь, үхэр, адууны мах нь хүн амын хэрэглээнд өндөр хувь эзэлдэг.

Төгсгөлд нь бид бүх нэр төрөл дээр үнэ сонгон авсан хугацаанд ямар хэмжээтэй өссөнийг тооцож, түүнээс үнэ нь хамгийн их өссөн нэр төрлүүдийг сонгон авав. Ингэхдээ 2013 оны 1 дүгээр сарын эцсийн үнийг 2010 оны мөн 1 – р сарын эцсийн үнэтэй, түүнчлэн 2013 оны 8 дугаар сарын эцсийн үнийг 2010 оны 8 дугаар сарын эцсийн үнэтэй харьцуулсан өсөлтийг тооцов. Энд жилийн тодорхой сарын хувьд адил байхаар харьцуулан авлаа. Дээр дурьдсан хугацаанд үнэ нь хамгийн их өссөн нэр төрлүүдийг хүснэгт 2.3 –д харуулав.



**Хүснэгт 2.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний дотроос үнэ нь хамгийн өссөн нэр төрлүүд, өсөлт дахинаар**

Үнийн өсөлт өндөртэй нэр төрөл	2013.01/2010.01	2013.08/2010.08
1. Õàèõ, ä° ðâ° èææí, "Ãàðí èöèèé", "Ýí äñýí õ¿í ñ"ÕÕÊ	1,406	1,445
2. Õí í èí û ì àõ, êã	2,587	1,938
3. Ýõðèéí ì àõ, êã	2,415	1,974
4. Ääóóí û ì àõ, êã	2,429	2,078
5. Í àðããðèí, "Ñòàí è-í í á", 500 ãð	2,101	2,019
6. Äèèì, ø àð, êã	2,240	1,737
7. Óèààí èí î èü, Õÿòàä, êã	1,646	1,451
8.ª ðã ñò òýì õ, Õÿòàä, êã	1,754	1,597
9. Õñ, 1.5è, Äèòàò èò	2,434	2,429
10. Äðòè, "Ñì èðí î õ õ", 0.75è, ääààää	2,183	2,092
11. Òí æóóð òàì òè, "THIS", Ñì èí í ã ñ	2,265	2,246
12. Òí æóóð òàì òè, "Äèòàí í àä÷", äí òí í ä	2,596	2,570
13. Ýðýýí äààäáóó, ì, í àðèéí ýí òýé, Í ðí ñ	1,667	1,506
14. Ýðýäýé õ¿í èé äí òí ðòí é èóððèä	1,852	1,925
15. Õðõñû, 100% õ° ä° í äààäáóó	2,151	1,961
16. Í î ñí í òàì õ, çàäããé ýí äýðòýé, òí ä÷òí é, Õÿòàä	1,674	1,806
17. Ýí ýäýé í î òóððàí òàì õ, 46-48 ðàçì áð, "Ãí äü" ÕÊ, äææì î áð	1,673	2,071

Дээрх 3 шалгуурыг харгалзан үнийг нь зохицуулах шаардлагатай нэр төрлүүдийг 2 ангилан тогтоов. Эхнийх нь уламжлалт байдлаар үнийг нь үндсэндээ бүрэн хянаж, зохицуулж, зохих хязгаарлалттай байлгасаар ирсэн бараа, бүтээгдэхүүн юм. Эдгээрт доорх 9 нэр төрөл орно.

1. Ахуйн хэрэглээний цахилгаанын 1 квт цагийн төлбөр
2. Шатахууны үнэ
3. Автобусны билетийн үнэ
4. Орон сууцны халаалтын үнэ
5. Ундны цэвэр усны үнэ
6. Их, дээд сургуулийн сургалтын төлбөр
7. Үр тариа улсад худалдан авах үнэ, урамшуулал
8. Гурилын үнэ
9. Талхны үнэ

Эдгээр бараа, бүтээгдэхүүнээс цахилгааны , шатахууны болон үр тарианы үнэ бусад бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээни зардлыг нэмэгдүүлж, улмаар үнэд нь шууд нөлөөлдөг тул зайлшгүй хяналтад байлгах шаардлагатай. Харин үлдсэн 6 нэр төрлийн хуьд хүн амын хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг тул эдгээр нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнэ өсөхөд хүн амын амьжиргаанд шууд муугаар нөлөөдөг учраас төрөөс хянаж, зохицуулсаар ирсэн. Иймээс бидний судалсан хугацаанд тодруулбал, 2010 оны 1 дүгэр сараас 2013 оны 8 дугаар сарын хооронд тэдгээрийн үнэ төдийлөн ихээр өсөөгүй тогтвортой байсаар иржээ. Хэрэв эдгээр нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг хяналтаас гаргаж, чөлөөлбөл инфляцийн өсөлт хяналтаас гарах аюултай.

Бид шинээр үнийг нь төрөөс хянаж, зохицуулах шаардлагатай нэр төрөлд дараахь 8 нэр төрлийг оруулахыг санал болгож байна.

**Хүснэгт 2.4 Шинээр үнийг нь төрөөс хянаж, зохицуулах шаардлагатай нэр төрөл**

Үнийг нь зохицуулах шаардлагатай шинээр нэмэгдэх нэр төрөл	Үндэслэл
1.Малын махны үнэ (хонь, үхэр, адууны махны үнэ)	Хэрэглээний бараа, бүтээгдэхүүний сагсанд өндөр хувийн жин эзэлдэг, судласан хугацаанд үнэ нь хамгийн их хэлбэлзэлтэй, хамгийн их өссөн.
2.Гар утасны төлбөр	Сагсанд өндөр хувийн жин эзэлдэг тул тариф нь ихээр өсвөл инфляцийн өсөлтөд маш их нөлөөтэй.
3.Нүүрс, түлээний үнэ	Сагсанд өндөр хувийн жин эзэлдэг, судалсан хугацаанд үнэ нь нэлээд хэлбэлзэлтэй, өсөлт дунд зэрэг.
4.Хүнсний ногооны үнэ	Сагсанд өндөр хувийн жин эзэлдэг, судласан хугацаанд үнэ нь хамгийн их хэлбэлзэлтэй байсан, хамгийн их өссөн.
5.Цагаан будааны үнэ	Сагсанд өндөр хувийн жин эзэлдэг
6.Импортын жимс, ногооны үнэ (Алим,Хятад улаан лооль, өргөст хэмх, Вьетнамын дарсан өргөст хэмх, Польшийн компот, кетчуп)	Сагсанд өндөр хувийн жин эзэлдэг, судласан хугацаанд үнэ нь хамгийн их хэлбэлзэлтэй байсан



**Хүснэгт 2.5 Гол нэрийн зарим бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт**

	Нэр төрөл	Дотоодын үйлдвэрлэл, үндсэн үнээр, сая төгрөг	Импорт	Нийт нөөц, үндсэн үнээр, сая төгрөг	Нийт нөөцөд эзлэх хувь	
					үйлдвэрлэл	импорт
1	Үр тариа	96 288,2	43 293,7	139 581,9	69,0	31,0
2	Хүнсний ногоо	51 443,3	14 800,4	66 243,7	77,7	22,3
3	Төмс	92 076,5	2 548,1	94 624,6	97,3	2,7
4	Жимс, самар	3 845,1	5 790,3	9 635,4	39,9	60,1
5	Мах, махан бүтээгдэхүүн	600 130,7	9 844,6	609 975,2	98,4	1,6
6	Гурилын үйлдвэрийн бүтээгдэхүүн	84 603,2	44 647,9	129 251,1	65,5	34,5
7	Талх, талхан бүтээгдэхүүн	62 967,7	27 381,6	90 349,3	69,7	30,3
8	Чулуун ба хүрэн нүүрс, хүлэр	927 465,1	130,4	927 595,5	100,0	0,0
9	Гуалин, бэлтгэсэн мод	34 300,6	14,6	34 315,2	100,0	0,0
10	Цагаан будаа	0,0	2540,8	2540,8	0,0	100,0

Эх үүсвэр: ҮСХ-ноос боловсруулсан нөөц, ашиглалтын хүснэгтийн тоо мэдээлэл, 2010 он

Хүснэгт 2.5- аас харахад манай оны хувьд 2010 онд нүүрс, хүлэр, модыг 100 хувь , харин мах, махан бүтээгдэхүүнийхээ хэрэгцээнийхээ 98,4 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байсан бол цагаан будаагаа 100 хувь импортоор авч нийлүүлжээ. Харин төмсний нийт хэрэгцээнийхээ 97.3 хувийг, хүнсний ногооны хэрэгцээнийхээ 77.7 хувийг, үр тарианыхаа 69 хувийг дотооддоо үйлдвэрлэн хангаж байжээ. Харин жимс, самарын хэрэгцээнийхээ 60 хувийг импортоор хангаж байв. Эндээс дэлхийн зах зээлийн үнээс хамааралтай байж болох импортын бүтээгдэхүүн цагаан будаа, жимс, самар л байна. Бусад нэр төрлийн бүтээгдэхүүний хувьд ихэнхийг нь дотооддоо үйлдвэрлэж байгаа нөхцөлд үнийг нь үндсэндээ зохицуулах боломжтойг харуулж байна.

Манай оронд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, хүнсний бараа, бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг албан ёсны зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн тоо 40 мянгаас давж байна. Дээр нь иргэд хувиараа олон мянгаараа хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, импортын үйл ажиллагаанд оролцож, хүнсний бараа, бүтээгдэхүүний зах зээлд туйлын эмх замбараагүй байдлыг үүсгэж байгаа нь хүнсний бүтээгдэхүүний үнэ бүрдэлт, олон гар дамжуулан үнэ өсгөх нөхцлийг бүрдүүлж, зоргоороо үнэ

нэмэх явдалд төрөөс хяналт тавих боломжийг маш хүндрүүлдэг. Худалдааны тухай одоо боловсруулж байгаа хуулинд хүнсний бүтээгдэхүүнийг импортлох, борлуулах эрхийг цөөхөн, томоохон компаниудад олгож, тэдгээрт тавих хяналтын тогтолцоог маш нарийн тогтоож өгөх шаардлагатай байна.

Доорх хүснэгтэд Монгол Улсын 2010 оны тоо мэдээллээр байгуулсан ашиглалтын хүснэгтээс гол нэрийн зарим бараа, бүтээгдэхүүний зах зээл дэх эрэлтийн хэмжээг харуулав. Энд нийт хэрэглээ буюу эрэлтийг худалдан авагчийн үнээр харуулсан бөгөөд энэхүү үнэ нь өмнөх хүснэгтэд харуулсан үндсэн үнээс тээвэр, худалдааны нэмэгдэл болон цэвэр татварын хэмжээгээр илүү байгаа болно.

**Хүснэгт 2.6 Гол нэрийн зарим бараа, бүтээгдэхүүний нийт эрэлт**

	Нэр төрөл	Нийт хэрэглээ, худалдан авагчийн үнээр, сая төгрөг	Үүнээс:			
			завсрын хэрэглээ	эцсийн хэрэглээ	хөрөнгийн хуримтлал	экспорт
1	Үр тариа	148451,6	127 755,3		20 696,3	
2	Хүнсний ногоо	82463,9	24 212,7	52 531,2	5 720,0	
3	Төмс	113774,5	17 034,5	77 596,6	19 143,4	
4	Жимс, самар	13037,3	2 508,2	10 518,2	6,0	4,781
5	Мах, махан бүтээгдэхүүн	737636,5	88 429,1	509607,1	56 444,5	83155,8
6	Гурилын үйлдвэ-рийн бүтээгдэхүүн	163672,0	38 376,8	116240,4	9 032,8	22,0
7	Талх, талхан бүтээгдэхүүн	115639,7	15 104,1	97 172,3	3 318,5	44,8
8	Чулуун ба хүрэн нүүрс, хүлэр	1183161,4	74 525,3	15 459,7	-87 163,4	1180339,7
9	Гуалин, бэлтгэсэн мод	40524,2	4 965,6	23 538,9	12 000,0	19,8

Эх үүсвэр: ҮСХ-ноос боловсруулсан нөөц, ашиглалтын хүснэгтийн тоо мэдээлэл, 2010 он

Нийт эрэлтийн дотоод бүтцийг илүү тодорхой харуулах зорилгоор дээрх хүснэгтийг доорх хэлбэрээр өөрчлөн харуулав.

**Хүснэгт 2.7 Гол нэрийн зарим бараа, бүтээгдэхүүний нийт эрэлтийн бүтэц, хувиар**

	Нэр төрөл	Нийт хэрэглээ, худалдан авагчийн эзлэх хувь	Үүнээс:			
			завсрын хэрэглээ	эцсийн хэрэглээ	хөрөнгийн хуримтлал	экспорт
1	Үр тариа	100	86,1		13,9	
2	Хүнсний ногоо	100	29,4	63,7	6,9	
3	Төмс	100	15,0	68,2	16,8	
4	Жимс, самар	100	19,2	80,7	0,0	0,04
5	Мах, махан бүтээгдэхүүн	100	12,0	69,1	7,7	11,3
6	Гурилын үйлдвэрийн бүтээгдэхүүн	100	23,4	71,0	5,5	0,01
7	Талх, талхан бүтээгдэхүүн	100	13,1	84,0	2,9	0,04
8	Чулуун ба хүрэн нүүрс, хүлэр	100	6,3	1,3	- 7,4	99,8
9	Гуалин, бэлтгэсэн мод	100	12,3	58,1	29,6	0,05

Эх үүсвэр: ҮСХ-ноос боловсруулсан нөөц, ашиглалтын хүснэгтийн тоо мэдээлэл, 2010 он

Хүснэгт 2.7- оос харахад 2010 онд үр тарианы нийт эрэлтийн 86,1 хувь нь үйлдвэрлэлийн зориулалттай, үлдсэн хэсэг нь хөрөнгийн хуримтлал хэлбэрээр ашиглагджээ. Хүнсний ногоо, төмс, мах, махан бүтээгдэхүүн, жимс, гурилын үйлдвэрийн бүтээгдэхүүн, талх, талхан бүтээгдэхүүний 63,7-84,0 хувь эцсийн хэрэглээний зориулалтаар, тодруулбал үндсэндээ хүн амын болон аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд зарцуулагджээ. Харин нүүрсний 99,8 , мах, махан бүтээгдэхүүний 11,3 хувь нь экспортод гарчээ.

Мал, махны нийт эрэлтийг биет хэмжээгээр илэрхийлэх зорилгоор хэрэглээнд зарцуулсан малын тоо толгойг доорх хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 2.8 Хэрэглээнд зарцуулсан малын тоо, малын төрлөөр, мянга**

	Хэрэгцээнд зарцуулсан мал		Үүнээс:					
			Хувийн хэрэглээнд		Дотоодын үйлдвэрлэлд		Экспортод	
	2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013
<b>Бүгд</b>	<b>9036,6</b>	<b>10205,0</b>	<b>8916,7</b>	<b>10089,0</b>	<b>79,6</b>	<b>96,7</b>	<b>40,4</b>	<b>19,2</b>
Адуу	226,9	225,7	222,8	215,4	0,2	1,2	3,9	9,2
Үхэр	437,8	445,6	424,9	436,8	9,8	8,8	3,1	0,0
Тэмээ	19,6	31,7	19,6	31,7	0,0	0,0	0,0	0,0
Хонь	4032,6	5015,3	3968,0	4946,6	48,5	58,5	16,1	10,1
Ямаа	4319,7	4486,6	4281,3	4458,5	21,0	28,2	17,3	0,0

Эх үүсвэр: ҮСХ, Мал, тэжээвэр амьтдын тооллогын дүн.

Улсын хэмжээнд 2012 онд 9 сая малыг хэрэгцээний зориулалтаар зарцуулж байсан бол 2013 онд 10,2 сая болж нэмэгджээ. 2013 оны байдлаар нийт малын хэрэгцээний 98,9 хувь нь хүн амын хувийн хэрэгцээнд, 0,9 хувь нь үйлдвэрлэлд, харин дөнгөж 0,2 хувь нь экспортод гарчээ. Малын төрлөөр нь авч үзвэл 2013 онд хэрэглээнд зарцуулсан үхрийн 98 хувь нь хувийн хэрэгцээнд, 2 орчим хувь нь үйлдвэрлэлд зарцуулагдаж, экспортод гаргаагүй байна. Харин хэрэглээнд зарцуулсан хонины 98,6 хувь нь хувийн хэрэгцээнд, 1,2 хувь нь үйлдвэрлэлд зарцуулагдаж, 0,2 хувь нь экспортод гарчээ.


**2.3 Монгол улсын гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн улирлын хэлбэлзэлд хийсэн шинжилгээ, нийлүүлэлтийн саад тотгорууд**

**Монгол Улсын инфляцад нөлөөлдөг гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн улирлын болон нийлүүлэлтийн хэлбэлзэл**

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь ихэнх улс оронд улирлын чанартай явагддаг. Үүний улмаас хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт нь улирлын шинжтэй, түүнээ дагаад үнэ нь улирлын хэлбэлзэлтэй өөрчлөгдөж байдаг.

Үнэ тогтворжуулах бодлого нь хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний энэ шинж төрхийг харгалзан эдгээр бүтээгдэхүүний үнийг тогтворжуулахад ихэвчлэн чиглэгддэг байна. Манай орны хувьд хүнсний бүтээгдэхүүний улирлын хэлбэлзэл ямар байгааг доорх зургаас харж болно.

**Зураг 2.1 Хэрэглээний нийт бараа, үйлчилгээний болон хүнсний бүтээгдэхүүний үнийн сүүлийн 8 жилийн сар бүрийн өөрчлөлт, хувиар**




Эх үүсвэр: ҮСХ-ны ХҮИ-ийн дэлгэрэнгүй тоо мэдээлэл

Зургаас бид тодорхой дараах 2 дүгнэлтийг хийж болохоор байна. Нэгдүгээрт хүнсний бүтээгдэхүүний үнэ ихээхэн тогтворгүй, хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн ерөнхий дундаж өөрчлөлтөөс илүү тогтворгүй өсөж, буурч иржээ. Энэ нь зурагт тэмдэглэгдсэн хүнсний бүтээгдэхүүний улаан шугам хөхөөр дүрслэгдсэн ХҮИ-ийн өөрчлөлтийн шугамаас байнга гадуур нь байрлаж, хэлбэлзэл ихтэй байгаагаас тодорхой харагдаж байна.

Хоёрдугаарт хүнсний бүтээгдэхүүний үнэ улирлын байнгын тогтсон хэлбэлзэлтэй байгаа нь сүүлийн 8 жилийн сар бүрийн өөрчлөлтийн чиг хандлагаас тодорхой харагдаж байна. Хүнсний бүтээгдэхүүний үнийн улаан шугамын оройнууд жил бүрийн 12-р сараас дараа оны 5 сарын хооронд байгаа нь энэ саруудад үнэ өсөж, түүний доош харсан оройнууд жил бүрийн 6-8 сард таарч байгаа нь энэ саруудад үнэ буурдаг ерөнхий зүй тогтолтой байгаа нь ажиглагдаж байна.

Нөгөө талаасаа хүнсний бүтээгдэхүүний үнэ хэрэглээний сагсанд байгаа нийт барааны дундаж үнээс илүү хурдан өссөөр ирснийг доорх Зураг-2.2-оос харж болно. 2013 оны 12 сарын үнийг 2005 оны 12 сарынхтай харьцуулахад нийт сагны үнэ дунджаар 2.5 дахин өссөн байхад хүнсний бүтээгдэхүүний бүлгийн үнэ 3 дахин нэмэгджээ.

**Зураг 2.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний болон хүнсний бүтээгдэхүүний үнийн суурь үетэй харьцуулсан өсөлт, 2005 оны 12 сар=100, хувиар**




Эх үүсвэр: ҮСХ-ны ХҮИ-ийн дэлгэрэнгүй тоо мэдээлэл



Зургаас харахад манай оронд хүнсний бүтээгдэхүүний үнэ инфляцийн өсөлтөнд голлох нөлөө үзүүлдэг нь тодорхой байна. Эндээс хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах нь инфляцийг хяналтандаа байлгах гол нөхцөл болж байна.

Өөр нэг анхаарал татаж байгаа асуудал бол манай оронд хүнсний бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээрх хүнсний бүтээгдэхүүний үнээс илүү хурдан өссөөр ирсэн явдал юм.

**Зураг 2.3 Дэлхийн болон Монголын зах зээл дэх хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн хувь, 2005=100**




Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо, ОУВС-н тоо мэдээ (WEO) судлаачийн тооцоо

2005 оны 12 сарыг суурь болгон авч үзэхэд 2012 оны 12 сар гэхэд Монгол дахь хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ 3 дахин өссөн бол дэлхийн хэмжээнд энэ үзүүлэлт 1.8 дахин өссөн дүнтэй гарчээ.

Инфляцийн болон хүнсний бүтээгдэхүүний үнийн улирлын хэлбэлзлийн шинж төрхийг улирлын индексээр илэрхийлж, Зураг -4–д харуулав.

**Зураг 2.4 Хэрэглээний бараа,үйлчилгааний болон хүнсний бүтээгдэхүүний үнийн улирлын индекс, 2006-2013 он**



Эх үүсвэр: ҮСХ-ны ХҮИ-ийн дэлгэрэнгүй тоо мэдээлэл

Улирлын хэлбэлзлийн индексийг тооцохдоо сүүлийн 8 жилийн сар бүрийн үнийн өсөлтөөс 13 сарын шаталсан дундажийг тооцож, 8 жилийн хувьд сар бүрийн үнийн өсөлтийн медиан утгыг үндэслэн улирлын индексийг тооцов.

Зураг-2.4-т харуулсан сүүлийн 8 жилийн тоо мэдээнээс харахад жилийн эхний улиралд инфляци ерөнхийдөө бусад саруудаас өндөр байдаг, харин 3 сараас 5 сар хүртэл бага зэрэг өсдөг, 5 сараас эргээд буурч, 8 сард бага зэрэг нэмэгдээд, 9,10 сард эргээд буурч, 11,12 сард дахин өсдөг давтамжтай байна. Харин хүнсний бүтээгдэхүүний үнэ жил бүрийн 8 болон 9 сард буурдаг, 10 сараас 1-р сар хүртэл өсдөг, 1-5 сарын хооронд үндсэндээ тогтвортой байснаа 5-р сараас буурч ирдэг ерөнхий зүй тогтол харагдаж байна. Харин хүнсний бүтээгдэхүүний үнийн улирлын хэлбэлзэл ХҮИ-ээс ч илүү гүнзгий байгаа нь зураг -3-аас тодорхой харагдаж байна.

Манай оронд хүнсний бүтээгдэхүүний үнэ бусад бараа, бүтээгдэхүүнтэй харьцуулахад илүү тогтворгүй өсөлт, бууралт илүү ихтэй байдаг нь “нийлүүлэлтийн шок” (supply shock) гэдэг үзэгдэл манайд байнга гарч байгаатай холбоотой. Энэ нь хөдөө аж ахуйн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт улирлын хамааралтай огцом өсөж, буурч байдагтай холбоотой үзэгдэл юм. Тухайлбал, монголчуудын хүнсний гол хэрэглээ болох малын махны нийлүүлэлт улирлын чанартай, намар, өвөл мал тарган үед болон


өвлийн идэш бэлтгэх үеэр махны нийлүүлэлт нэмэгдэж, үнэ нь буурдаг. Үүний зэрэгцээ малчид оюутан хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөхийн тулд 8-9 сард мал олноор нь нядалж, махаа борлуулж, орлогоор нь сургалтын төлбөрийг төлдөг. Монголчууд хавар, зуны эхээр хүйтэн хахир өвлийг дөнгөж давж, сульдаж турсан малыг нядалдаггүй, нядлахад махны гарц нь бага ашиггүй байдаг бөгөөд энэ үед махны нийлүүлэлт эрс багасаж, үнэ нь нэмэгддэг онцлогтой.

Газар тариалангийн бүтээгдэхүүний хувьд ч мөн нийлүүлэлт нь улирлын шинжтэй ихэсч, буурдаг. Намар төмс, хүнсний ногоо хураан авсны дараа нийлүүлэлт ихсэж, үнэ нь буурдаг бол хавар, зун нийлүүлэлт багасаж, үнэ нь өсдөг. Хүнсний ногоо хадгалах зоорьны аж ахуй муу хөгжсөн, ногоо хадгалах зоорь хүрэлцээгүйгээс газар тариалан эрхэлдэг аж ахуй, иргэд ногоогоо жилийн турш жигд нийлүүлж, борлуулж чаддаггүй нь үүнд нөлөөлдөг.

Иймээс макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, инфляцийн огцом өсөлтийг гаргуулахгүй байхын тулд Засгийн газар “нийлүүлэлтийн шок”-ыг аль болох арилгах бодлогыг урт хугацаанд авч хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдаж байна. Үүний тулд мах, хүнсний ногоо зэрэг хөдөө аж ахуйн гол бүтээгдэхүүний нийлүүлэлтийг жилийн турш тогтвортой байлгах нөхцлийг бий болгоход хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй нягт хамтран ажиллах шаардлагатай байна. Тухайлбал, хөргүүлтэй махны зоорь, ногоо хадгалах зоорийг хангалттай олноор байгуулах нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой байлгах хамгийн чухал нөхцөл болох юм.

Монгол Улсын инфляцад нөлөөлдөг гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн улирлын болон нийлүүлэлтийн хэлбэлзэлийг доорх зургуудад харуулав.

**Зураг 2.5 Хэрэглээний бараа, үйлчилгээний болон хонь, үхрийн махны сүүлийн 8 жилийн сар бүрийн үнийн өөрчлөлт, хувиар**




Эх үүсвэр: ҮСХ-ны ХҮИ-ийн дэлгэрэнгүй тоо мэдээлэл

Зураг-2.5-аас хонь, үхрийн махны үнэ улирлын ихээхэн хэлбэлзэлтэй, жил бүрийн 12 сараас дараа оны 6 сар хүртэл үнэ өсөөд 6 сараас 8 сард үнэ нь буурдаг давтамж харагдаж байна. Нөгөө талаасаа хонь, үхрийн махны үнэ хоорондоо их уялдаатай, аль нэгний үнэ өсөхөд нөгөөгийнх үнэ дагаж өсдөг нь харагдаж байна. 2006-2010 онуудад махны үнийн өсөлтийн шугам 2 оройтой, тухайлбал, ихэвчлэн 2 болон 5 дугаар саруудад махны үнэ ихээхэн огцом өсдөг байжээ. Харин 2011 оноос хойш 5 -р сарын үний огцом өсөлт нь бараг алга болж, шугам ганц оройтой болж, зөвхөн 1-2 дугаар сард махны үнэ өсдөг болжээ. Зургаас харахад 2012 оны намраас Засгийн газар махны үнийг тогтворжуулахад илүү амжилт олж, цоройсон огцом өсөлт гараагүй байна.

Зургаас нийт инфляцийн өсөлт, бууралтад махны үнэ мэдэгдэхүйц нөлөөтэй болох нь харагдаж байна. Хэрвээ махны үнийн огцом өсөлт, бууралтыг багасгаж чадвал инфляцийн түвшин илүү тогтвортой болох нь тодорхой байна. Энэ нь хэрэглээний бараа, үйлчилгээний сагсны жингийн 13 хувийг энэхүү 2 бүтээгдэхүүн эзэлдэгтэй бас холбоотой.


**Зураг 2.6 Дэлхийн болон Монголын зах зээл дэх үхрийн махны үнийн өсөлтийн хувь, 2005=100**



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо, ОУВС-н тоо мэдээ (WEO) судлаачийн тооцоо

**Зураг-2.6.**–гаас харахад манай оронд үхрийн махны үнэ дэлхийн зах зээл дээрх үнээс үлүү тогтворгүй, хурдацтай өсөж иржээ. 2005 оны 12 сараас 2013 оны 3 сар хүртэлх үхрийн махны үнэ нийтдээ 3.7 дахин өссөн (хэдийгээр энд харуулаагүй боловч хонины махны үнэ энэ хугацаанд 4 дахин өссөн) байгаа нь үхрийн махны дэлхийн зах зээлийн үнэтэй харьцуулахад ихээхэн өндөр байгаа юм. Зургаас харахад 2008 оны эдийн засгийн хямрал, 2009-2010 оны ган, зудны улмаас махны нийлүүлэлт багасаж, махны үнэ огцом өсөж байсаныг харж болно.


**Зураг 2.7 . Хэрэглээний бараа,үйлчилгээний болон хүнсний ногооны сүүлийн 8 жилийн сар бүрийн үнийн өөрчлөлт, хувиар**



Эх үүсвэр: ҮСХ-ны ХҮИ-ийн дэлгэрэнгүй тоо мэдээлэл

Хүнсний ногооны үнэ мөн л улирлын ихээхэн хэлбэлзэлтэй байгааг бид зургаас харж байна. Жил бүрийн 5-7 сард үнэ нь огцом өсөөд, эргээд 8-9 сард буурдаг давтамжтай байна. Ялангуяа луувангийн үнэ ихээхэн тогтворгүй байсаар иржээ. Харин төмс, байцааны хувьд мах болон луувантай харьцуулбал үнийн улирлын хэлбэлзэл багатай байгааг ажиглаж болно.


**Зураг 2.8 Хэрэглээний бараа,үйлчилгааний болон гурил, цагаан будааны сүүлийн 8 жилийн сар бүрийн үнийн өөрчлөлт, хувиар**



Эх үүсвэр: ҮСХ-ны ХҮИ-ийн дэлгэрэнгүй тоо мэдээлэл

Гурил, цагаан будааны хувьд улирлын чанартай тогтвортой хэлбэлзэл ажиглагдахгүй байгаа бөгөөд гурилын хувьд 2007 оны зун, 2008 оны эхний улирал болон 2010 оны зун үнэ нь огцом өссөн байгаа нь харагдаж байна. Цагаан будааны хувьд 2008 оны хавар, өнгөрсөн 2013 оны 4-р улиралд үнэ нь ихээхэн огцом өсөж байжээ. 2007-2008 оны хувьд дэлхийн санхүү, эдийн засгийн хямралтай холбоотойгоор импортын гурил, цагаан будааны үнэ дэлхийн зах зээл дээр огцом өссөнтэй холбоотой (Зураг-2.9, 2.10.) байна.

**Зураг 2.9 Дэлхийн болон Монголын зах зээл дэх гурилын үнийн өсөлтийн хувь, 2005=100**




Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо, ОУВС-н тоо мэдээ, судлаачийн тооцоо

Монгол дахь гурилын үнийн өөрчлөлтийг дэлхийн гурилын үнийн өөрчлөлттэй харьцуулбал ойролцоо түвшинд байна (Зураг-2.9). Үнийн хэлбэлзлийн хувьд Монголын гурилын үнийн хэлбэлзэл дэлхийн гурилын үнийн хэлбэлзлээс ерөнхийдөө бага байжээ. 2007-2008 оны дэлхийн эдийн санхүү, засгийн хямралын улмаас дэлхийн зах зээл дээр гурилын үнэ огцом өссөн нь манайд бас нөлөөлсөн нь харагдаж байна. Манай оронд 2008 оны 4 сараас хойш гурилын үнэд томоохон өөрчлөлт гараагүй нь гурилынхаа хэрэгцээг дотоодын улаан буудайгаар хангах тал дээр ахиц дэвшил гарч, импортоос хамаарах хамаарал буурсантай холбон тайлбарлаж болно.

Дэлхийн зах зээл дээр цагаан будааны үнэ 2007-2008 оны дэлхийн эдийн санхүү, засгийн хямралын улмаас огцом өсөж байсан бол Монголд үнийн өсөлтийн хурд нь арай багавтар байжээ. Гэвч 2010 оны зунаас дэлхийн зах зээл дээр цагаан будааны үнэ буурч байхад Монголд эсрэгээрээ цагаан будааны үнэ нэлээд өсөж байжээ (Зураг-10). Харин 2010 оноос хойш цагаан удааны үнэ манай оронд харьцангуй тогтвортой хадгалагдаж иржээ.




**Зураг 2.10 Дэлхийн болон Монголын зах зээл дэх цагаан будааны үнийн өсөлтийн хувь, 2005=100**



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо, ОУВС-н тоо мэдээ, судлаачийн тооцоо

Дэлхийн зах зээлд цагаан будааны үнэ буурч байхад Монгол эсрэгээрээ өсөж байсныг Шудрага өрсөлдөөн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага анхааралдаа авч, байнгын судалгаа, мэдээлэлтэй байж, цаашид ийм үзэгдлийг гаргуулахгүй байх, тодорхой арга хэмжээг авч байх шаардлагатай нь харагдаж байна.

**Зураг 2.11 Хэрэглээний бараа,үйлчилгээний болон түлшний мод, нүүрсний сүүлийн 8 жилийн сар бүрийн үнийн өөрчлөлт, хувиар**




Эх үүсвэр: ҮСХ-ны ХҮИ-ийн дэлгэрэнгүй тоо мэдээлэл

Харин гэр хорооллын өрхийн түлшний мод, нүүрсний эрэлт, хүйтний улиралд нэмэгддэгтэй холбоотойгоор үнэ нь өсдөг улирлын байнгын тогтсон хэлбэлзэл байгаа нь Зураг 2.11-ээс харагдаж байна. Гэхдээ 2006,2007, 2008 оны болон 2011 оны 9-11 сарын хооронд нүүрсний үнэ, харин 2007,2008 оны 9-11 сарын хооронд түлээний модны үнэ огцом нэмэгдэж байжээ.

Сонирхолтой нь 11-ээс 2 сарын хооронд өвлийн ид хүйтний үед түлээ, нүүрсний үнэ төдийлөн өсөөгүй, харин ч буурсан байна.

**Зураг 2.12 Хэрэглээний бараа,үйлчилгээний болон шатахууны сүүлийн 8 жилийн сар бүрийн үнийн өөрчлөлт, хувиар**




Эх үүсвэр: ҮСХ-ны ХҮИ-ийн дэлгэрэнгүй тоо мэдээлэл

Сүүлийн 8 жилийн байдлаар шатахууны үнэнд улирлын тодорхой тогтсон хэлбэлзэл ажиглагдахгүй байна. Энэ хугацаанд шатахууны үнэ 3 удаа огцом өссөний эхнийх нь дэлхийн санхүү,эдийн засгийн хямралтай холбоотойгоор 2008 оны намар тохиосон бол 2009 оны эхээр 2 дахь удаагийн огцом өсөлт гарсан боловч хавар нь эргээд буурч, харин зун нь дахиад 3 дахь огцом өсөлт гарч байжээ. Эндээс 2009 оны хувьд шатахууны үнэ тун тогтворгүй байсан нь харагдаж байна. Харин 2010 оноос хойш шатахууны үнийн хэлбэлзлийн давтамж цөөнч, 2012 оноос хойш өмнөх жилүүдтэй харьцуулахад шатахууны үнэ харьцангуй тогтвожсон байна.

Шатахуун нь бүх бараа, бүтээгдэхүүний үнэд тодорхой хэмжээгээр нөлөөдөгийг Зураг-12-оос харж болно. 2007 оны зунаас 2008 оны хавар хүртэл шатахууны үнэ 4 удаа тогтворгүй хэлбэлзсэний улмаас 2007 оны намраас 2008 оны зун хүртэл инфляцийн ерөнхий түвшин нэлээд өссөн харагдаж байна. 2010 оны эхээр, 2011 оны зун шатахууны үнэ бага боловч өссөн саруудад ХҮИ дагаад өссөн байна.

Манай оронд шатахууны үнэ өссөн мөчлөгийг Зураг-13 –д үзүүлсэн дэлхийн зах зээл дэх шатахууны үнийн өсөлт гарсан хугацаатай зэрэгцүүлэн үзэхэд 2008 оны 10 сараас 2009 оны 1 сарын хооронд дэлхийн зах зээлд шатахууны үнэ үнэхээр огцом өсч байжээ.

**Зураг 2.13 Дэлхийн зах зээл дээрх шатахууны үнийн хэлбэлзэл**



Эх үүсвэр: [www.oil-price.net](http://www.oil-price.net)

Дэлхийн зах зээл дэх шатахууны үнийн дараагийн өсөлт 2011 оны хавар тохиосон бол манай оронд 2011 зун шатахууны үнэ өсөж байжээ.

## **БҮЛЭГ 3. Үнийг нь зохицуулах шаардлагатай гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ бүрдэлтийн байдал, нийлүүлэлтийн саад хязгаарууд**

### **3.1 Монгол Улсын өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ бүрдэлтийн байдал**

### **3.2. Улаанбаатар хотын хэрэглэгчдийн махны хангамжийн замын зураглал**

Монголчуудын өдөр тутмын гол хэрэглээний нэг бөгөөд үнийн хэлбэлзэл өндөр бүхий бүтээгдэхүүн болох махны хангамжийн зураглалыг, судалгааны аргачлалын дагуу, Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж, нийслэлийн хэрэглэгчдийн махны хэрэгцээг үндсэндээ хангаж байдаг захуудад тандан судалгаа хийх замаар гаргав.

Судалгааг эхний ээлжинд Эмээлт, Налайх дахь түүхий эдийн зах, “Хүчит шонхор”, “Хархорин”, “Баянзүрх”, “Амгалан” захууд дээр төвлөрүүлэн, “Бөмбөгөр”, Барс, “Таван Эрдэнэ” хүнсний зах, мах худалдаалдаг зарим дэлгүүрийг хамруулан хийсэн.

Судалгааны мэдээллийг асуулгын хэлбэрээр цуглуулж, тухайн захуудад ажиллаж байгаа:

- ченж,
- худалдагч нартай ярилцлага хийсний зэрэгцээ тухайн бүтээгдэхүүний борлуулалт, үнэ бүрдэлтийн онцлогийг харгалзан мэдээллийн бодит байдлыг сайжруулах зорилгоор, захуудын:
- менежерүүд, малын эмч, эрүүл ахуйч эмч, - лабораторийн эмч нар болон харъяалсан дүүргийн мэргэжлийн хяналтын байцаагч нартай уулзаж, ярилцлага хийв.

Махны үнэ бүрдэлтэд нөлөө үзүүлж буй, тухайн бүтээгдэхүүний борлуулалтын бүх шат дамжлагууд буюу өнөөдөр бүрдэн, хэрэгжиж байгаа махны өртгийн сүлжээний бүрдэл хэсгүүдийг тухайн бүтээгдэхүүний замын зураглал гаргах зангилаа цэгүүд болгож, бүрэн хамруулахыг зорьсон болно. Үүнээс хамааран, өмчлөлийн талаасаа шилжилт гарах нь ховор боловч зардал нэмж буй тээвэрлэлт, нядалгаа зэргийг бие даалган тусгалаа. Жич, энд татвар хураамжийг оруулаагүй. Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тогтоогддог, гарал үүслийн гэрчилгээ олгосны төлбөр хураамж нь харилцан адилгүй, жишээлбэл, Улаанбаатарт 1 кг махнаас 150 төгрөг авдаг байна.

Судалгааны дунд шатанд бүх аймгийн мэдээллийг газар дээрээс нь цуглуулав. Ингэхдээ, мэдээллийг тухайн аймаг орон нутагт ажиллаж амьдарч буй бизнесийн сургагч багш нараар дамжуулан авав.

Судалгааны сүүлийн шатанд судалгааны багийнхан Дархан-Уул, Баянхонгор, Ховд, Завхан, Хөвсгөл, Сэлэнгэ аймгуудад очиж ажиллан, судалгааны материалыг газар дээр нь нарийвчлан нягтлав.

Энэ бүхний үндсэн дээр нийслэлийн хэрэглэгчдийн нэг гол хэрэглээ болох махны хангамж, үнэ бүрдэлтийн өнөөгийн байдалд үнэлгээ, дүгнэлт хийлээ.

Нийслэлийн хэрэглэгчид/иргэд/-ийн махны хангамжийн замын зураглал нь улирлаас хамааран ялгаатай гарч байна. Мах нь борлуулалтын сүлжээндээ амьд мал, бэлтгэсэн мах гэсэн үндсэн 2 хэлбэртэй байдаг. Тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл, боломж, тээврийн зардлаас хамааран, дулааны болон хүйтэн сэрүүний улиралд амьд мал, бэлтгэгдсэн мах хэлбэртэйгээр борлуулалтын сүлжээгээр дамждаг.

Урин дулааны улиралд амьд мал нийслэл хүртэл авто машинаар тээвэрлэгдэж ирдэг. Тээврийн зардал нь алслалтын хэмжээ, автомашины багтаамж зэргээс хамааран ялгаатай байдаг. Жижиг оврын ачааны машинд 22 хонь, чиргүүлтэй, том оврын авто машинд 220 хүртэл хонь тус тус багтаж, тээвэрлэгддэг байна. Бусад төрлийн малын тухайд хонин толгойд шилжүүлдэг коэффициентийг ашиглаж болохоор байх юм. Хамгийн холоос, тухайлбал, Увс аймгаас болон Завхан аймгийн баруун сумдаас 1 хонь 15 000 орчим төгрөгөөр тээвэрлэгдэн ирж байна.

Мах нь хүйтэн сэрүүний улиралд бэлтгэгдэж, хөлдөөсөн хэлбэрээр тээвэрлэгддэг. Энэ үед тээврийн хэрэгслийн багтаамж, даац дундажаар 5 дахин нэмэгдэж ашиглагдах учир тэр хэмжээгээр зардал буурдаг. Жишээлбэл, дээр дурьдсан Увс аймгаас болон Завхан аймгийн баруун сумдаас 1 кг мах 200-300 төгрөгөөр буюу нэг хонины мах дундажаар 4000-5000 төгрөгийн хөлсөөр тээвэрлэгдэн нийслэлд ирж байна.

Урин дулааны цагт орон нутгаас ирж байгаа амьд мал нь Эмээлт, Налайх дахь цэгүүдэд нядлагдан нийслэлийн зах зээлд нийлүүлэгддэг.

Эмээлтэд мал нядалгааны 8 цэг байгаагаас 3 нь 1000 хүртэл, 5 нь 300-аас 800 хүртэл бог мал өдөртөө нядлах хүчин чадалтай нь хашаа, талбайн хэмжээ, ажиллагсад, дэгээний тооноос тус тус хамаардаг байна. Орон нутгаас мал ирэх байдал, зах зээл дээрх махны үнэ ханшаас хамааран эдгээр хүчин чадлын ашиглалт өдөр бүр харилцан адилгүй байдаг. Нядалгааны 8 газрын 2 нь л агуулах савтай байна. Нядалгааны газруудын гол зорилго нь малын арьс ширийг авах явдал юм. Энд 2013 оны улиралд 1 хонийг 2500-аар нядалж, арьс ширийг нь хятадуудын авч буй үнэнээс 1000 төгрөгөөр багаар үнэлэн авсан байна. Нядлуулсан малынхаа махыг авч ирсэн ченжүүд нь шөнөдөө ачиж, “Хүчит шонхор” зах дээр үүрээр бөөндөж зардаг. Багахан хэсгийг нь “Хархорин”

зах дээр бөөнддөг, ялангуяа Архангайгаас гаралтай мах тус зах дээр ахиу борлогддогийг энэ зах дээр тухайн аймгаас гаралтай ченжүүд түлхүү ажилладагтай холбон тайлбарлацгааж байна. Эмээлтэд Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Булган, Дундговь аймгаас болон Төв аймгийн ихэнхи сумдаас мал ирдэг. Ховд, Баян-Өлгий аймгаас маш ховор үзэгддэг байна. Энэ нь эдгээр аймагт мах комбинат ажилладаг, мах экспортолдогтой холбоотой ажээ.

Налайхад мал нядалгааны цэг, шинэ тутам байгуулагдсныг нь оруулаад 7 байна. Эдгээр цэг тус бүрийн хүчин чадал нь дундажаар, богд шилжүүлснээр, өдөрт 400 орчим хонь нядалдаг. Эмээлтээс ялгарах зүйлс нь бод мал нилээд ирдэг, Сүхбаатар/50-60%/, Хэнтий/25-30%/, Дорнод/10-15%/, Төв, Дорноговь зэрэг бусад/5-10%/ аймгуудаас мал мах ирдэг, бог малыг 3500-аар нядалдаг, махны тодорхой хэсэг/10-15%/ “Нарантуул”, “Баянзүрх”, “Амгалан” захуудад бөөнддөг зэрэг болно.

Хүйтэн сэрүүний улиралд нядалгааны цэгүүд ажилладаггүй, харин Эмээлт, Налайхын аль алинд нь мах худалдаж авах цэгүүд ажилладаг боловч харьцангуй бага хэмжээтэй бөгөөд авсан махаа “Хүчит шонхор”, “Хархорин”, “Баянзүрх”, “Нарантуул” захуудад бөөнөөр нь борлуулдаг байна. Жишээ нь өмнө дурьдсан, нийслэлийн махны хангамжийн үндсэн урсгалын зэрэгцээ “Нөөцийн мах” гэсэн салаа урсгал үүсч, мах борлуулалтын сүлжээнд тодорхой хувь эзэлж, эерэг сөрөг нөлөө үзүүлж ирсэн. Энэ өвөл гэхэд 13000 тонн мах бэлтгэж, борлуулалтаа хийж буй бөгөөд үнэ ханш нь зах зээлийн бөөний үнээс дээгүүр байна, тухайлбал, “Хүчит шонхор” зах дээр энэ оны 1 дүгээр сарын сүүлийн хагаст махны бөөний үнэ харьцангуй тогтвортой байж, хонины ястай мах 5500 орчим байхад нөөцийнх 5750, нөөцийн үхэр, ямааны шулсан мах захуудын жижиглэнгийн үнэтэй ижил, зарим тохиолдолд бүр өндөр байна. Энэ нь нөөцийн махыг орон нутгаас бэлдэхийн оронд зарим хэсгийг нь хот руу орж ирж байгаа махны урсгалаас бэлтгэдэгтэй холбоотой. Хот руу орж ирсэн махнаас нөөцлөх нь мах хөлдөх үеэр нийлүүлэлт нэмэгдэж үнэ буурдаг байдлыг өөрчилж, үнэ тогтворжуулах бус тодорхой тохиолдолуудад үнэ хөөрөгдөх нөхцөл үүсгэж байна.

Ер нь нийслэлийн махны хангамж, нийлүүлэлт, үнэ бүрдэлтийг тодруулахын тулд энэ үйл ажиллагаанд оролцдог “махны ченж” гэж нэрлэгддэг хүмүүсийг 2 ангилж үзэх нь зүйтэй юм. Малчид, орон нутгаас мал, мах авч, нийслэлд оруулж ирж байгаа хэсгийг “нийлүүлэлтийн”, нийслэлд орж ирсэн махыг худалдаалдаг хэсгийг “борлуулалтын” гэж нэрлэвэл зохистой.

Судалгааны дүнгээс үзэхэд “нийлүүлэлтийн” ченж 1 килограмм махны үнийг 1000-1500 төгрөгөөр нэмэгдүүлж байна. Энд 1500 километр хүртэл зайд

тээвэрлэх болон нядалгааны зардал тус тус орж байгаа болно. “Хүчит Шонхор” захаас эхэлж буй “борлуулалтын” ченж, махны худалдагч нарын үйл ажиллагааны хүрээнд махны үнэ 1500-аас 5000 хүртэл төгрөгөөр нэмэгдэж байгаа бөгөөд агуулах сав, бандангийн түрээс, хотын доторхи тээврийн зардал, мах эвдэх ажлын хөлс энд багтаж байгаа болно.


Нөөцийн мах бэлтгэлийн тухайд сөрөг нөлөөг нь дараах байдлаар тайлбарлаж болно гэж үзэж байна. Үүнд:

1. Орон нутгаас нөөцийн мах бэлтгэхдээ аймгийн төвд л авч байгаа нь малчдаас авсан мал, махыг бага даацын олон машинаар аймгийн төв хүртэл зөөж, тэвш солин ачиж буулгах болон завсрын нийлүүлэгчид нэмэгдэх замаар зардал, үнэ өсөх,
2. Нийслэл рүү орж ирж байгаа махны урсгалаас тосч бэлтгэснээр мах хөлдөх үед хангалт нэмэгдэж, үнэ буурдаг эерэг байдлыг үгүй болгох/ингэж авахын тулд тодорхой үнэ зарладаг нь үнийг дороос нь тулж, түүнээс хямд үнэ байхгүй нөхцлийг бүрдүүлдэг/,
3. Махны “нийлүүлэлтийн” ченжүүд зарласан үнээр нь улсын нөөцөд мах нийлүүлэхдээ чанар муутай махаа ялгаж ангилж борлуулдаг нь зах зээл дээр илүү хямд үнээр гарч, хэрэглэгчдийн төлбөрийн чадвар муутай хэсэгт очих махны урсгалыг хиймлээр таслалдуулдах зэрэг болно.

Судалгааны мэдээлэлд үндэслэн, Улаанбаатар хотын хэрэглэгчдийн махны хангамжийн замын зураглалыг улирлын онцлогийг харгалзан гаргаж, дүрслэн харуулав/Зураг 3.1/.




Зураг 3.1 Улаанбаатар хотын хэрэглэгчдийн махны хангамжийн замын зураглал



Тайлбар: Нарийн зураасаар амьд малын, тод зураасаар бэлтгэсэн махны урсгалыг тус тус илэрхийлэв.

Улаанбаатарт нийлүүлэгдэж буй махны хэмжээг аймаг тус бүрээр хувьлан харуулав/Зураг 3.2/.

Зураг 3.2 Улаанбаатарт нийлүүлэгдэж буй махны хэмжээг аймаг тус бүрээр хувьлан харуулав/Зураг 3.2/.



Нийслэлд мах борлуулах шат дамжлагыг бууруулахад саад болж буй нэг хүчин зүйл нь захууд мах ачсан машин зогсох, бөөний арилжаа хийх хэмжээний талбай байхгүй, байсан ч хүрэлцээгүй жижиг байдагтай холбоотой юм.


Нийслэлийн зүүн хэсэгт, өнгөрсөн оны 11 дүгээр сарын 29-нд “Амгалан” зах шинээр нээгдсэн нь энэ чиглэлд гарсан ахицтай, ололттой алхам болсон. Тус зах нь хүрэлцээтэй хэмжээний зам талбай бүхийн зэрэгцээ, төв замын дэргэд байрлалтай, сайтар тоноглогдсон, орчин үеийн шаардлага хангасан 500 тоннын багтаамжтай зоорь, тус бүр нь 250 тоннын багтаамжтай 2 агуулахтай нь зүүн аймгуудын мал, махны хувьд өнөөгийн “Хүчит шонхор” захын үүргийг гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлж байна.

**3.3. Улаанбаатар хотын гэр хорооллын хэрэглэгчдийн түлээ, нүүрсний хангамжийн замын зураглал ба үнэ бүрдэлтийн байдал**

Улаанбаатар хотын гэр хорооллын хэрэглэгчдийн түлээ, нүүрсний хангамжийн шат дамжлагыг 5 болон 7 буудлын ойролцоо гудамжинд түлээ, нүүрс зардаг цэгүүд, “Цайз” захын орчмын нүүрс, түлээний цэгүүдийг хамруулан цагаан сарын өмнөхөн 1 дүгээр сарын 25-27 –ны өдрүүдэд тандан судлав. Эдгээрийн зэрэгцээ Засгийн газраас Багануурын нүүрсийг савлан зарж байгаа цэгүүд гэр хороололд олон байсан бөгөөд том ногоон шуудайтай нүүрс 3200 төгрөгөөр зарагдаж байлаа.

Дээрх цэгүүдэд зарагдаж байгаа нүүрсний (Багануурын зохион байгуулалттай зарж буй нүүрс ороогүй) ойролцоогоор 80 хувь нь Налайхын уурхайгаас гар аргаар олборлосон нүүрс, бусад нь Алаг толгой болон Шивээ- Овоогийн нүүрс байлаа.


**Зураг 3.3 Нүүрс нийлүүлэлтийн замын зураг**



Багануурын нүүрсийг зөвхөн зохион байгуулалттай тусгай цэгүүдээр зарж, бусад цэгүүдэд үндсэндээ огт зарахгүй байна. Энэ нь Бага нуурын нүүрсийн зориуд хямд үнээр зохион байгуулалттай зарж байгаатай холбоотой байна.

Налайхаас нүүрсийг 2 янзаар зөөж авчирч байна. Нэг хэсэг нь УБ-Налайхын хооронд нүүрс зөөдөг чэнжүүд, нөгөө хэсэг нь Налайхад гар аргаар нүүрс олборлодог хүмүүс өөрсдөө хотод авчирч, гэр хорооллын цэгүүдэд тараан зарж байна. Ингэхдээ нүүрсээ мөн 2 төрлөөр зарж байна. Бөөнөөр зарж байгаа нь “ковшин” гэж ярьж заншсан хэмжээтэй нүүрсийг Налайхад 40-45 мянган төгрөгөөр худалдан авч болдог бөгөөд хотын цэгүүдэд өгдөг үнэ нь 60-80 мянга болдог байна.

### Зураг 3.4 Налайхын нүүрсний үнэ бүрдэлтийн байдал



Энд тээврийн зардал ороод ингэж нэмэгддэг ажээ. Ковшин гэгч хэмжээс нь нүүрсийг газрын гүнээс татаж гаргадаг том төмөр ванн бөгөөд 3 ковшин нь 2.5 тоннын портерийн тэвшийг бараг дүүргэдэг гэж хэлж байв. Өөр нэг хэмжээс нь 25 кг-ын гэгдэх шуудай бөгөөд зарим нь Налайхдаа ийм шуудайнд шуудайлаад энд хотын цэгүүдэд 2200- гаар зараад, цэгүүд нь иргэдэд 2500 гаар зарж, шуудай нүүрс бүрээс 300 төгрөгийн ашиг унагаж байв. Ковшиноор нь худалдан авсан хүмүүс өөрсдөө шуудайлаад мөн шуудайг нь 2500- гаар зарж байлаа. Дээрх схемээс харахад нүүрсний эцсийн хэрэглэгчийн үнийн ойролцоогоор 33-44 хувь нь тээврийн зардал, худалдааны нэмэгдэл байна.

“Цайз” захын орчмын нүүрс, түлээний цэгүүдэд 2.5 тоннын портертэй Налайхын нүүрс 260 мянган төгрөгөөр зарна гэж байлаа. Эдгээр портерүүд нь айлдаа шууд хүргэж өгдөг тул айлынхаа хол ойроос хамаараад үнэ бас хөдөлгөдөг ажээ. Нэг 2.5 тоннын портерийг 3 ковшин гэж үзвэл 260 мянгаар бодоход нэг ковшин нь 86 мянган төгрөг болж байна. Энэ нь айлдаа хүргэх

унааны зардлаа багтаасан тул дээрх нэг ковшин 60-80 мянгаар зардаг гэдэгтэй ойртож байна.


Нүүрсний үнэ “Цайз” захын орчимд арай хямд, гэр хорооллын цэгүүдэд арай үнэтэй байв. Гэр хороолол дотроо бас өөр өөр үнэтэй байв. Тухайлбал, Налайхын 25 кг-ын шуудайтай нүүрс “Цайз” захын орчимд 2300 төгрөг байхад 5 болон 7 буудалд 2500, хойшоо зуслангийн замд 2700 төгрөг байв. “Цайз” захын орчимд Алаг Толгойн нүүрс дээрх хэмжээний шуудай нь бүр 3500 төгрөг байв. Найлайх, Алаг Толгойн нүүрс гэж зараад байгаа нүүрсүүд нь бас дотроо ялгаатай зарим цэг дээрээ Налайхын нүүрсийг Засгийн газраас зохион байгуулж, савлаж зардаг Багануурын нүүрстэй хольж зардаг газрууд ч цөөнгүй байгаа ажээ. Энэ нь шуудайныхаа аман хэсэгт Налайхын нүүрсээ хийж, дунд болон доод хэсэгт нь Багануурын нүүрс байна гэсэн үг юм.

Түлээний хувьд гарал үүсэл нь тун тодорхой бус, дээрх цэгүүдээс асуухад тодорхой хүмүүс машинаар нь ачиж ирж, бөөнөөр зардаг гэж байв. Жижиг шуудай модыг 2500 төгрөгөөр, том шуудайтай модыг 5 мянгаар зарж байсан бөгөөд модны ченжүүд дээрх цэгүүдэд том шуудайтай модыг 4 мянгаар бөөнддөн ажээ. Хүмүүс модны талаар хариулт өгөх дургүй, сайн мэдэхгүй гэж цааргалж байгаагаас үзэхэд ихэнх нь буруу гарын буюу хулгайн мод, иргэд өөрсдөө уулнаас зөвшөөрөлгүй бэлтгэсэн мод бололтой байна.


**Орон нутаг дахь нүүрсний хангамжийн замын зураглал**

**Зураг 3.5 Орон нутаг дахь нүүрсний нийлүүлэлтийн замын зураг**


Баруун бүсийн аймгууд:




**Хангайн бүсийн аймгууд:**



**Төвийн бүсийн аймгууд:**



Зүүн бүсийн аймгууд:



Зураглалаас харахад орон нутагт аль болох ойр газраас нүүрсээ татаж ашиглаж байгаагийн дээр тээвэрлэлтийн зай болон нүүрсний чанараас хамааран үнэ нь өөр өөр байна. Хамгийн хямд үнэтэй нүүрсийг Дорнод амйгийн Чойбалсан хотынхон дэргэдээ байгаа Адуунчулууны уурхайгаасаа тонныг нь 16 мянган төгрөгөөр авч ашиглаж байгаа бол Төв аймгийн төв Зуунмод хотынхон Налайх,Багануурын нүүрсийг тонныг нь мянгаар авч , хамгийн үнэтэй нүүрс хэрэглэж байна.

### 3.4. Импортын цагаан будааны замын зураглал

Гаалийн статитикийн мэдээнээс харахад Монгол улсын цагаан будааны нийт импортын 65-67 хувийг хятад улсаас импортолж байна. Хятад улс цагаан будаа тариалалтаараа дэлхийд тэргүүлдэг хэдий ч дотоодынхоо хэрэгцээг хангаж чаддагүй мөн сратегийн чухал бүтээгдэхүүн гэж үзээд экспортлохыг хориглодог учраас манай хувь хүмүүс импортоор оруулж ирэх хандлага өндөр байна. Мөн ОХУ-аас нийт цагаан будааны импортын 13.7-28.1 хувийг хангаж байна. Сүүлийн 3 жилд ОХУ-с импортлох цагаан будааны хэмжээ өсөх хандлагатай байна. Цагаан будааг импортоор оруулж ирээд борлуулахад нэлээд шат дамжлагаар явж дунджаар 50 хоног зарцуулж байж Улаанбаатар хотод борлуулж байна.

**Хүснэгт 3.1 Цагаан будаа импортолж, борлуулах замын зураглал**

№	Гүйцэтгэгч	Байрлал	Хоног	Зардал /төг/	Үйл ажиллагаа	Хандах байгууллага	
1	Импортлогч	Замын-Үүд	2		Импортын зөвшөөрөл хүссэн өргөдөл өгөх	МХЕГ	
2			12	60000-80000	Загвар, дээж өгөх	МХЕГ, МХЕГ-ын лаборатори	
3					Байцаагч томилох	МХЕГ	
4					Байцаагчаас дүгнэлт гаргуулах	МХЕГ	
5			1	5000	Импортын гэрчилгээ авах	МХЕГ	
6			2	133 юань/тонн	Ачааны машинд ачуулж тээвэрлэх	Хилийн МХЕГ	
7			2	5000+7000	Гаальд мэдүүлэх, гаалийн бүрдүүлэлт хийх	ГЕГ	
8					татвар	ГЕГ, Банк, МХЕГ-ын лаборатори,	
9			20	/хэмжээнээс хамаарах/ төлбөр	Татвар төлөх, биет шалгалтанд орох	Бусад итгэмжлэгдсэн лаборатори	
10					Вагоноор УБ- руу ачуулах	УБТЗ, тээврийн байгууллага	
11			УБ	12	135000	Дээж өгөх	МХЕГ-ын лаборатори
12			УБ	51 х	60000-80000	Дээжийн шинжилгээ өгөөд дүгнэлт гаргуулах	МХЕГ-ын лаборатори
				<b>Зах зээлд борлуулах</b>			

Эх үүсвэр: МҮХАҮ-ийн тэнхим, “Монгол Улсад бизнес хийх замын зураглал”

Цагаан будаа нь импортлогчоос эцсийн хэрэглэгч хүртэл нэлээд хэдэн зуучлалаар дамжин хүрч буйг доорхи хүснэгтээс харж болохоор байна.


**Хүснэгт 3.2 Гаалиас эцсийн хэрэглэгч хүртэлх цагаан будааны үнэ, төгрөгөөр**

Гаалийн үнэ	Импортлогчийн үнэ	Хүнсний захын үнэ	Сүлжээ дэлгүүрийн үнэ
580	1200	2200	2800
Өсөлтийн хувь	206.9%	183.3%	127.3%

Орон нутагт борлуулагдаж буй цагаан будааны үнийг статистикийн мэдээнд суурилан харьцуулж үзэхэд дунджаар 100-200 төгрөгөөр хэлбэлзэж байна.Энэ нь голлон тээврийн зардлаас хамаарч байна.



Зураг 3.6 Цагаан будааны замын зураглал



**3.5. Төмс, хүнсний ногооны нийлүүлэлтийн замын зураг**

Монгол Улс жилдээ 191-245 мянган тонн төмс тариалж байгаа нь нийт нийлүүлэлтийн 97-99 хувь болж байна.

**Хүснэгт 3.3 Төмсний үйлдвэрлэл, импорт, тонн**

	2011	2012	2013	2011	2012	2013
<b>Дотоод</b>	201,638.9	245,934.97	191,619.2	97.2%	98.7%	100.0%
<b>Импорт</b>	5,779.99	3,162.44	31.99	2.8%	1.3%	0.0%
<b>Дүн</b>	<b>207,418.9</b>	<b>249,097.4</b>	<b>191,651.2</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>

Сүүлийн жилд дотоодын тариалалтын хэмжээ өсч нийлүүлэлт нэмэгдсэнтэй уялдан төмсний үнэ нэлээд тогтвортой хүнсний захуудад нэг кг төмс 800-900 төгрөгөөр, сүлжээ дэлгүүрүүдэд 900-1000 төгрөгөөр борлогдож байна. Сүлжээ дэлгүүрүүд төмсийг голлон савлаж борлуулж байгаатай уялдан үнэ бага зэрэг нэмэгдэж байна.

Сүүлийн 2 жилд байцааны үнэ нэлээд тогтвортой нийлүүлэтээс хамааран зарим саруудад буурах хандлагатй байна. Улаанбаатар хотын гол захуудад нэг кг байцаа 1000-1200 төгрөг, сүлжээ дэлгүүрүүдэд 1200-1500 төгрөг байна.

### 3.6 Шатахууны үнэ бүрдэлт

Хүснэгт 3.4 Шатахууны үнэ 2014 оны 4 дүгээг сарын 20 –ны байдлаар

Өртөг	Нормаль-80		Регуляр-92		ДТ /өвөл/	
	SIFS	SIFS-гүй	SIFS	SIFS-гүй	SIFS	SIFS-гүй
Хилийн үнэ	1014 \$/тонн		1105 \$/тонн		1080 \$/тонн	
Татвар /1 литр/	200		199		226	
Ханш нөлөөлөл	1441	1767	1441	1767	1441	1767
Бусад зардал /1 литр/	137		141		160	
Жижиглэнгийн үнэ	<b>1550</b>	<b>1646</b>	<b>1660</b>	<b>1804</b>	<b>1790</b>	<b>2115</b>

Долларын ханшийг 2014 оны 2 сарын дунджаар тооцоолов. Хилийн үнийг 2014 оны 3 сард Наушик боомтын ипортын дундаж үнээр авав

## Дүгнэлт

1. Манай орны хэрэглээний үнийн 2006-2013 оны сар бүрийн өсөлтийн байдлаас харахад хүнсний бүтээгдэхүүний үнэ ихээхэн тогтворгүй, хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн ерөнхий дундаж өөрчлөлтөөс илүү тогтворгүй өсөж, буурч иржээ (Зураг-2.1.). Энэ байдал нь инфляцийн өсөлтөд хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт голлох нөлөөг үзүүлж байгааг харуулж байна. Хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах нь инфляцийг хяналтандаа байлгах гол нөхцөл болж байна.
2. Сүүлийн 8 жилийн сар бүрийн мэдээллээс харахад хүнсний бүтээгдэхүүний үнэ жил бүрийн 12-р сараас дараа оны 5 сарын хугацаанд өсч, жил бүрийн 6-8 саруудад үнэ буурдаг ерөнхий зүй тогтолтой байна.
3. Хүнсний бүтээгдэхүүний үнэ тогтворгүй байгаа нь манай оронд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь улирлын чанартай тул мах, сүү, төмс, хүнсний ногоо гэх мэтийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт нь улирлын шинжтэй, үүнээсээ болоод үнэ нь улирлын хэлбэлзэлтэй өөрчлөгдөж байна.
4. Өөр нэг анхаарал татаж байгаа асуудал бол манай оронд хүнсний бүтээгдэхүүний үнэ 2008 оны зунаас хойш дэлхийн зах зээл дээрх хүнсний бүтээгдэхүүний үнээс илүү хурдан өссөөр ирсэн байна. 2005 оны 12 сарыг суурь болгон авч үзэхэд 2012 оны 12 сар гэхэд дэлхийн хэмжээнд хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ 1.8 дахин өссөн бол Монголд 3 дахин өссөн байна.
5. Импортын хүнсний бүтээгдэхүүний хувьд дэлхийн зах зээлийн үнийн өсөлт болон валютын ханшны чангаралт дотоод зах зээлд үнийн өсөлтөд нөлөөлж байгаа нь цагаан будааны үнийн хэлбэлзэлээс харагдаж байна. (Зураг-2.8-ыг харна уу.)
6. Үнийг нь зохицуулах шаардлагатай гол нэрийн бараа, бүтээгдэхүүний дотор хүнсний бүтээгдэхүүнийг нэн тэргүүнд хамруулах шаардлагатай нь дээрх дүгнэлтүүдээс урган гарч байна.
7. Манай оронд иргэд хувиараа олон мянгаараа хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, импортын үйл ажиллагаанд оролцож, хүнсний бараа, бүтээгдэхүүний зах зээлд туйлын эмх замбараагүй байдлыг үүсгэж байгаа нь хүнсний бүтээгдэхүүний үнэ бүрдэлт, олон гар дамжуулан үнэ өсгөх нөхцлийг бүрдүүлж, зоргоороо үнэ нэмэх явдалд төрөөс хяналт тавих боломжийг маш хүндрүүлж байна.
8. Сүүлийн 8 жилийн сар бүрийн мэдээллээс харахад бараа, бүтээгдэхүүний суурь үнэд голлон нөлөөдөг шатахууны үнийн

хэлбэлзлийн давтамж 2010 оноос хойш цөөнч, 2012 оноос хойш өмнөх жилүүдтэй харьцуулахад шатахууны үнэ харьцангуй тогтворжсон байна. Засгийн газраас шатахууны үнийг тогтворжуулах талаар авсан арга хэмжээнүүд үр дүнгээ өгсөн байна. (Зураг 2.12-ыг харна уу).

9. Засгийн газраас хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах хөтөлбөр нь үнийг өсгөх “эндоген” хүчин зүйлийн нөлөөг арилгахад хэрэгцээтэй бөгөөд гагцхүү оновчтой зөв хэлбэрээр хэрэгжүүлбэл үр дүнгээ өгнө гэдгийг шатахууны үнийг тогтворжуулах арга хэмжээ харууллаа.

10. Манай оронд шатахууны үнэ нь түүний дэлхийн зах зээлийн үнээс хамааралтайгаар тодорхой хугацааны дараа өсөж ирсэн нь судалгаанаас харагдлаа.

11. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд хамгийн өндөр хувийн жин /5,4-7,9%/ эзэлдэг, үнийн хэлбэлзэл нь 30%-иас давсан хонь, үхрийн махны үнийг тогтворжуулах талаар Засгийн газраас онцлон анхаарах хэрэгтэй байна.

12. Нөөцийн мах бэлтгэх замаар махны үнийг тогтворжуулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр дүн муутай, зорилгодоо хүрэхгүй байна.

13. Тууврын зам байхгүй болсонтой холбогдон хөдөө орон нутгаас нийслэлд мал оруулж ирэхдээ зөвхөн авто тээврийг ашиглаж байгаа нь тээврийн зардлыг эрс өсгөж байна. Малыг амьдаар нь тээвэрлэх, нядлаад махыг нь тээвэрлэх зардлууд 3-5 дахин зөрөөтэй байна. Одоогоор орон нутагт хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажилд оролцож буй том оврын авто тээврийн хэрэгслүүд орон нутгаас тээвэрлэх мал махны тээврийн зардлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлж байна. Энэ байдал өөрчлөгдөхөд тээврийн зардал илүү их нэмэгдэж байна.

14. Гол хэрэглээ болсон махны суурь үнийг бүрдүүлэгч, нядалгааны зорилгоор арилжаалагдаж байгаа малын үнэ эмх замбарааг байдалтай байна.

15. Нийслэлийн махны хангамжийн зангилаа цэг болсон “Хүчит Шонхор” зах дээр бөөний болон жижиглэн худалдаа зэрэгцэн явж байгаа нь махны үнийн талаарх бодит мэдээллийг бүрхэгдүүлэхийн зэрэгцээ хиймэл, нэмэлт шат дамжлага бий болгох замаар үнийг хөөрөгдөж байна.

## Санал, зөвлөмж

### Засгийн газарт:

1. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, инфляцийн огцом өсөлтийг гаргуулахгүй байхын тулд Засгийн газар ямар ч бүтээгдэхүүний хувьд “нийлүүлэлтийн шок”-ыг аль болох арилгах бодлогыг урт хугацаанд авч хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

2. Төрөөс явуулах үнэ тогтворжуулах бодлого нь нэн тэргүүнд хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн улирлын хэлбэлзлийг арилгахад чиглэгдэх, тодруулбал хүнсний бүтээгдэхүүнийг жилийн турш тогтвортой нийлүүлэхэд чиглэгдэх шаардлагатай байна.

3. Хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн улирлын хэлбэлзлийг багасгах, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахын тулд мах нөөцлөх хөргүүлтэй зоорь, төмс, хүнсний ногооны зориулалтын зоорийг олшруулах чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагууд хамтран ажиллах шаардлагатай байна. Зориулалтын зоорь болон агуулахын аж ахуйн чиглэлээр хувийн хэвшлийн аж ахуйд татаас болон хөнгөлттэй зээлд хамруулах санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй.

4. Хүнсний үнэд тавих хяналтыг чангатгах, үнийг үндэслэлгүйгээр өсгөх явдлыг гаргуулахгүй байх хууль эрх зүйн шинэ орчинг бий болгох шаардлагатай байна. Тухайлбал, дэлхийн зах зээл дээр үнэ нь өсөөгүй байхад манай оронд үнэ өсөөд байгаа явдалд судалгаа хийж, хяналт тавьж, учир шалтгааныг тогтоож байх, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцож байх үүргийг Шудрага өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө агентлагт хуулиар олгох хэрэгтэй байна.

5. Худалдаа зохицуулалтын чиглэлээр хуультай болох, ингэснээр энэхүү тайлангийн 3.2-т дурьдсанчлан “борлуулалтын” ченж нарын үндэслэлгүйгээр үнэ хөөрөгддөг байдлыг таслан зогсоох зохицуулалт бүхий эрх зүйн орчин бүрдүүлэх

6. Худалдааны тухай хуульд дараахь заалтыг оруулах:

6.1. Хүнсний бүтээгдэхүүнийг импортлох, борлуулах эрхийг цөөхөн, томоохон компаниудад олгож, тэдгээрт тавих хяналтын тогтолцоог маш нарийн тогтоож өгөх

**Үндэслэл:** Хүнсний худалдааг иргэд, хувь хүмүүс олноороо эрхэлж байгаа нь үнэд тавих хяналтыг бэрхшээлтэй болгож, олон гар дамжуулан үнэ өсгөх нөхцлийг бүрдүүлж байгааг энэхүү худалдааны хуулиар зохицуулах шаардалагтай байна.

7. Нөөцийн мах бэлдэж, үнийн зохицуулалт хийх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг өнөөгийн байдлаар үргэлжлүүлэхээс татгалзах, экспортын зориулалтаар бэлтгэсэн махаар интервенц хийх, эсвэл сум,

багийн түвшинд хүрч гэрээ байгуулах замаар бэлтгэх зэрэг зохион байгуулалтын үр ашигтай шинэ арга хэлбэрт шилжүүлэх,

8. Махны нийлүүлэлтэд хөдөө аж ахуйн биржийг татан оролцуулах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх,

**Нийслэл, аймаг, сумдын ИТХ, Засаг дарга нарт:**

9. Сумдад мал нядалгааны цэг, хөргүүртэй зоорь, агуулах бий болгох ажлыг “сум” төслийн хүрээнд хийгээд төр хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн шийдвэрлэх, түүнчлэн мал тээвэрлэлтийг зогсоож, технологийн тээвэр зохицуулалтын асуудлыг шийдэх замаар зөвхөн мах хэлбэрээр тээвэрлэн, зардал хэмнэж, нийслэл болон төв суурин газруудын махны хангалт, үнийг тогтворжуулах,

10. Малыг амьдын жингээр авч бэлтгэх жишиг үнийг биржийн болон дуудлага худалдаа зэргээр бүсчлэн тогтоох замаар амьд малын үнийг баримжаатай, тогтвортой болгох,

11. Нийслэлийн баруун талд “Амгалан” захтай ижил төстэй захыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгох замаар “Хүчит Шонхор” захын монополь байдлыг эвдэх,

12. Орон нутагтаа мал эмнэлгийн хяналт бүхий, эрүүл ахуйн шаардлага хангасан нядалгааны цэгийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгох,

## Ном зүй

1. Цагдèì áàðàà áγòúüãúöγγí èé үí èéí өñèèò, òγγí èé óчèð ø àèòãàì, Монголбанк
2. 2013 оны хүнсний гол нэрийн барааны үнийн судалгаа, өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал
3. *Махны зах зээлийн судалгаа, Монголын хөрөнгийн зах зээлийн холбоо ТББ*
4. МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ, Дэд хөтөлбөр батлах тухай
5. Performance and Cost – Roadmap ECE Toronto Lecture Notes
6. Price-based and Cost-based Regulations for a Monopogy with Quality Choice, *Yukihiko Kidokoro*
7. Regulation: price cap and revenue cap, Mark A. Jamison
8. Drawing a Roadmap for Oil Pricing Reform, *Masami Kojima*
9. Ireland: Sectoral Road Map: Pigs
10. *Brazilian Beef A Roadmap to Sustainability*
11. Sectoral Road Map:Mid-season Lamb Production
12. The Australasian beef industries—Challenges and opportunities in the 21st century
13. The Price of Regulation , by Daniel Sperling
14. National Bureau of Economic Research
15. *Canada’s Beef food system, CAPI*
16. The Effects of Price Transparency Regulation on Prices in the Healthcare Industry
17. *The Effect of Economic Regulation, Paul.L.Joskow and Nancy.LRose*
18. A Sustainable Future, The Welsh Red Meat Roadmap
19. REPUBLIC OF THE PHILIPPINES CONGRESS OF THE PHILIPPINES, FIFTH REGULAR SESSION
20. *The Problems of Price Controls, By Fiona M. Scott Motron*
21. Pricing power: using price strategy roadmaps and tools to maximize bottom-line results
22. Rice Self-Sufficiency Bulletin
23. Price Regulation of Utilities
24. Meat Sector Policy Note: Reducing Price Instability in the Mongolian Meat Market, 2010
25. *Актуальные вопросы тарифного регулирования в 2013 году и задачи на 2014 год*
26. Дорожная карта о ценообразовании на лекарства
27. Пост-релиз по итогам ежегодного форума "Биржевая торговля нефтепродуктами в РФ"
28. План мероприятий ("дорожная карта") "Развитие конкуренции и совершенствование антимонопольной политики"
29. Маркетинговое исследование. Рынок охранных услуг. Март 2013

30. Российский рынок розничной торговли продуктами питания. Маркетинговое исследование и анализ рынка
31. Маркетинговое исследование "Российский рынок козьего молока и продуктов его переработки"
32. Российский рынок хлеба, маркетинговое исследование и анализ рынка (обновление 2011)
33. *Формирование международных цен на уголь*